

Монгол Улсын экспортыг дэмжих бодлогын нөлөөллийн үнэлгээ

Б. Түвшинтөгс
Ч. Нарантуяа
Б. Мөнх-Ирээдүй
Д. Өнөржаргал
Б. Хорол-Эрдэнэ

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн

Хураангуй

Энэ судалгаагаар Засгийн газар, бусад төрийн бус байгууллагын хэрэгжүүлж буй уул уурхайн бус экспортыг дэмжихэд чиглэсэн бодлогуудын хэрэгжилт, нөлөөллийг авч үзсэн. Судалгааны хүрээнд экспортыг дэмжихэд чиглэсэн институцийн зохион байгуулалт, үйл ажиллагаа болон бодлогын баримт бичгүүдийг шинжилж, экспортыг дэмжих бодлогын үр нөлөөг салбарын болон үндэсний түвшинд үнэлсэн.

Судалгаагаар Бела Балассагийн боловсруулсан “Илэрсэн харьцангуй давуу тал”-ын аргыг (1965) ашиглан Монголын уул уурхайн бус бүтээгдэхүүнүүдийг үнэлэхэд ноос ноолуур, нэхмэл болон арьс ширэн эдлэл зэрэг бүтээгдэхүүн харьцангуй давуу талтай байв.

Мөн Андерсон, Викүүп нарын боловсруулсан “Даацтай таталцлын загвар” (2003)-ыг ашиглан манай улстай худалдаа хийдэг 35 түнш орны 7 жилийн панел тоон өгөгдлийг ашиглан Засгийн газрын уул уурхайн бус экспортыг дэмжих бодлогын нөлөөг үнэлэв.

Түлхүүр үгс:

Экспорт, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт, экспортыг дэмжих бодлого

Монгол улс, Улаанбаатар хот

2018

Эдийн Засгийн Судалгаа Эрдэм Шинжилгээний Хүрээлэн



**Монгол Улсын экспортыг дэмжих бодлогын
нөлөөллийн үнэлгээ**

Эцсийн тайлан

УЛААНБААТАР

2018

“Монгол Улсын экспортыг дэмжих бодлогын нөлөөллийн үнэлгээ”

Эцсийн тайлан

Багийн ахлагч:

Гишүүд :

Б. Түвшинтөгс (Ph.D)

Ч. Нарантуяа (Ph.D)

Б. Мөнх-Ирээдүй

Д. Өнөржаргал

Б. Хорол-Эрдэнэ

УЛААНБААТАР

2018

АГУУЛГА

1. ОРШИЛ.....	6
2. ЭКСПОРТЫН САЛБАРУУДЫН ТОЙМ.....	8
2.1 Экспортын гүйцэтгэл	8
2.2 Экспортыг дэмжсэн бодлогууд.....	14
2.2.1 Экспортыг дэмжих үндэсний бодлогууд.....	15
2.2.2 Экспортыг дэмждэг байгууллагууд – институтийн бүтэц.....	20
2.2.3 Экспортыг дэмжих бодлогын арга хэрэгсэл	24
3. ЭМПИРИК ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ.....	29
4. ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ БОДЛОГЫН САЛБАРУУДАД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ	30
4.1. Ноос, ноолуур, нэхмэл бүтээгдэхүүний салбар.....	32
4.2. Арьс шир, арьс ширэн бүтээгдэхүүний салбар	34
4.3. Экспортын бусад салбар.....	35
5. ТӨЛӨВЛӨЖ БАЙГАА ЗАСГИЙН ГАЗРЫН БОДЛОГЫН ҮР НӨЛӨӨ.....	38
5.1 “Монгол Экспорт 2018” хөтөлбөрийн зорилго, зорилт.....	38
5.2 Үндсэн шалгуур үзүүлэлтүүд.....	44
6. НИЙТ ЭКСПОРТЫН ШИНЖИЛГЭЭ – ТАТАЛЦЛЫН ЗАГВАР.....	50
7. СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН, БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ	53
НОМ ЗҮЙ	59
ХАВСРАЛТ	61

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Экспорт, тэрбум ам.доллар.....	8
Зураг 2. Уул уурхайн ба уул уурхайн бус салбарын нийт экспортод эзлэх хувь	9
Зураг 3. “Эрдэс бүтээгдэхүүн” ба “сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос”-ны уул уурхайн салбарын экспортод эзлэх хувь	10
Зураг 4. Уул уурхайн бус салбарын экспорт, сая ам.доллар	10
Зураг 5. Гол уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүний нийт уул уурхайн бус экспортод эзлэх хувь.....	11
Зураг 6. Уул уурхайн бус салбарын экспортод ялгаварлалгүй болон ялгаварлалтай бүтээгдэхүүний эзлэх хувь.....	12
Зураг 7. Уул уурхайн бус экспорт, салбараар, сая ам.доллар.....	31
Зураг 8. Нэхмэлийн экспорт, сая ам.доллар	33
Зураг 9. Нэхмэлийн салбарын ЭИХДТ индекс	33
Зураг 10. Арьс шир, арьс ширэн бүтээгдэхүүний экспорт, сая ам.доллар	34
Зураг 11. Арьс шир, арьс ширэн бүтээгдэхүүний ЭИХДТ индекс	34
Зураг 12. Суурь металын экспорт, сая ам.доллар	35
Зураг 13. Машин, тоног төхөөрөмжийн экспорт, сая ам.доллар.....	35
Зураг 14. Ургамлын төрлийн бүтээгдэхүүний экспорт, сая ам.доллар	36
Зураг 15. Мах, малын гаралтай бүтээгдэхүүний экспорт, сая, ам.доллар	36
Зураг 16. Үнэлгээний үр дүн.....	52
Зураг 17. Хугацааны-санамсаргүй нөлөөний шалгуур.....	53

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Монголын нийт экспорт, түнш орнуудаар, хувиар	13
Хүснэгт 2. Эрдсийн бус экспорт, түнш орнуудаар, хувиар	14
Хүснэгт 3. Засгийн газрын гадаад худалдааны чиг үүрэг.....	21
Хүснэгт 4. Экспортын илэрсэн харьцангуй давуу тал (ЭИХДТ), тэргүүлэх салбараар	32
Хүснэгт 5. “Монгол Экспорт 2018” хөтөлбөрийн зорилтуудад санал болгож байгаа өөрчлөлтүүд.....	39
Хүснэгт 6. “Монгол Экспорт 2018” хөтөлбөрийн дагуу авах арга хэмжээ (шинээр зохион байгуулагдсан)	40
Хүснэгт 7. Монгол Экспорт 2018 Хөтөлбөрийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд.....	44
Хүснэгт 8. “Бизнес эрхлэхүй” тайлан 2018: Хил дамнасан худалдаа.....	48
Хүснэгт 9. Монгол Экспорт 2018 хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийн тухай санал.....	49

ТОВЧИЛСОН ҮГС

АХБ	Азийн хөгжлийн банк
ЕХ	Европын холбоо
ГХОГХА	Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийг
ГХА	Германы хөгжлийн агентлаг
ЗГ	Засгийн газар
ЖАЙКА	Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг
ГХЯ	Гадаад харилцааны яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
МҮХАҮТ	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
СЯ	Сангийн яам
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
АНУОУХА	АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ДНХШ	Дэлхийн нэгдсэн худалдааны шийдэл
ДХБ	Дэлхийн худалдааны байгууллага

1. ОРШИЛ

Монгол Улс далайд гарцгүй, жижиг нээлттэй эдийн засагтай, ДНБ-ий ихээхэн хэсэг гадаад худалдаанаас хамааралтай улс билээ. 2016 онд ДНБ-ий 85.9 хувийг экспорт, импорт бүрдүүлж байсан бөгөөд энэ нь Монгол Улс гадаад худалдаанаас ихээхэн хамааралтай болохыг харуулж байна. 2009-2015 онд Монгол Улсын экспорт 1.9 - 4.7 тэрбум ам.доллар, импорт 1.1 - 3.8 тэрбум ам.долларт тус тус хүрч гадаад худалдаа 2-3 дахин өссөн.

Гэсэн хэдий ч Монгол Улс бусад хөгжиж буй орнуудын адилаар экспортын төрөлжилтөөр хоцронгуй байна. Монголын экспортын гол бүтээгдэхүүнүүд нь нүүрс, алт, зэс зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн байдаг. 2016 оны байдлаар уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт нийт экспортын 13.6 хувийг эзэлж байгаа бөгөөд үүнээс 12.2 хувь нь ялгаварлалгүй буюу ХАА-н гаралтай түүхий эд байгаа бол дөнгөж 1.4 хувь нь ялгаварлалтай бүтээгдэхүүн байна.

Сүүлийн үед томоохон ашигт малтмалын орд газруудыг илрүүлж, ашиглаж эхэлсэн нь улс орны эдийн засагт томоохон боломжуудыг олгож байна. Гэсэн хэдий ч уул уурхайн баялаг хэд хэдэн асуудлуудыг үүсгэж байгаа бөгөөд нэг гол асуудал нь уул уурхайгаас хэт хамааралтай байдал юм. Иймээс бодлого боловсруулагчид эдийн засгийг төрөлжүүлэхэд анхаарах шаардлага тулгамдаж байна. Дотоодын зах зээлийн багтаамж багатай, харьцангуй бага орлоготой цөөн тооны хүн амтай манай улсын хувьд экспортыг дэмжих нь эдийн засгийг төрөлжүүлэх гол арга мөн. Гадаадын том зах зээлийг онилох нь уул уурхайн бус бүтээгдэхүүнийг илүү үр ашигтайгаар ашиглах буюу өргөжилтийн үр өгөөжийг бий болгоход тусална.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас өрсөлдөөнт эдийн засагт шилжиж, 1997 онд Дэлхийн худалдааны байгууллага /ДХБ--д элссэнээс хойш Монгол Улс гадаад худалдааны чөлөөт /либерал/ бодлоготой болохыг эрмэлзсээр ирсэн. Экспортыг дэмжих бодлого нь Монголын хувьд харьцангуй шинэ төрлийн үзэгдэл юм. Монголын гадаад худалдааны болон экспортыг дэмжих бодлого нь 1970-1980 оны Зүүн Ази, саяхны Латин Америкийн орнууд болон ихэнх хөгжиж буй оронтой адил үйлдвэрлэлийн тусгай бодлого биш юм. 2013 онд “Экспортыг дэмжих хөтөлбөр” баталсан нь экспортын салбаруудыг дэмжихээр оролдсон хамгийн анхны Засгийн Газрын цогц хөтөлбөр байсан. Экспортыг дэмжих энэхүү санаачилга жижиг дунд үйлдвэрлэл /ЖДҮ/ болон салбарын хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн зарим төсөл шиг Засгийн Газрын хөтөлбөрүүдэд түлхүү чиглэжээ. Гэвч Засгийн газар эдгээр бодлогыг зохицуулж чадахгүй, хэтэрхий тархай бутархай байна.

Энэ судалгаа нь Монгол Улсын Засгийн газар болон бусад төрийн бус байгууллагуудын хэрэгжүүлж буй экспортыг дэмжих бодлогын нөлөөг үнэлэх зорилготой. Энэ хүрээнд

бид институцийн зохион байгуулалт, бодлогын баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийсэн. Бодлогын үнэлгээнд бид экспортыг дэмжих бодлогын институцийн дараах загваруудыг хэрэглэнэ: шаталсан, төвлөрсөн бус, олон ургалч, хувийн шинжтэй. Мөн улс төр, эдийн засаг, засаг захиргааны хүрээнд бодлогын институтийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийсэн. Экспортыг дэмжих бодлогын үр нөлөөний шинжилгээг салбарын болон үндэсний гэх мэт өөр өөр түвшинд хийв.

Салбарын түвшинд Бела Балассагийн боловсруулсан “Илэрсэн харьцангуй давуу тал”-ын аргыг ашиглан Монгол Улсын хувьд аль салбарын бүтээгдэхүүн харьцангуй давуу талтай болохыг тодорхойлсон бөгөөд тэдгээр нь ноос ноолуур, нэхмэл болон арьс шир, арьс ширэн эдлэлийн салбар байсан. Үүнээс гадна бид экспортын хэмжээ, хөрөнгө, хөдөлмөрийн багтаамжаас хамааруулан эдийн засаг болон хөдөлмөр эрхлэлтэд ихээр нөлөөлдөг зарим салбарыг тодорхойлсон. Бид нийт үйлдвэрлэлийн нөхцөл, экспортолдог улс орнууд, салбарын онцлог бодлогын талаар илүү нарийвчилсан мэдээллийг 6 салбарт тодруулсан. Тэдгээр салбар нь ноос ноолуур, нэхмэл, арьс шир, арьс ширэн бүтээгдэхүүн, үндсэн төмөрлөг, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, мах болон бусад малын гаралтай бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмжийн салбар юм.

Бид тусдаа нэг бүлэгт одоогийн хэлэлцэж байгаа “Монгол экспорт хөтөлбөр” болон “Засгийн Газрын мөрийн хөтөлбөр 2016-2020”-ыг үнэлэх оролдлого хийлээ. Ялангуяа хөтөлбөр, хөтөлбөрийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдэд тусгагдсан зорилго, хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар зарим нэг жижиг нэмэлт өөрчлөлтийг санал болгосон.

Макро эдийн засгийн түвшинд бид газар зүйн байрлал, худалдааны түншүүдийн хөгжил дэвшлийг харгалзан үздэг “Таталцлын загвар”-ыг ашигласан. Тухайлбал Андерсон, Викүүп нарын хөгжүүлсэн “Даацтай таталцлын загвар” (2003)-ыг ашиглалаа.


Энэхүү судалгаа нь дараах бүтэцтэй. 2-р бүлэгт сүүлийн арван жилийн худалдааны ерөнхий статистикууд, хэрэгжүүлсэн экспортыг дэмжих бодлогуудын талаар авч үзнэ. 3-р бүлэгт судалгаанд ашиглаж байгаа эмпирик судалгааны арга зүй, тоон мэдээллийг тайлбарласан. 4-р бүлэгт экспортын салбаруудад шинжилгээ хийв. 5-р бүлэгт 2018 оны Монгол экспорт хөтөлбөрт зарим нэмэлт өөрчлөлтийг санал болголоо. 6-р бүлэгт “таталцлын загвар” ашиглах, хөгжүүлэх замаар экспортын динамикийг тайлбарласан. Эцэст нь бид үндсэн дүгнэлт, зарим бодлогын зөвлөмжийг дэвшүүлэв.

2. ЭКСПОРТЫН САЛБАРУУДЫН ТОЙМ

2.1 Экспортын гүйцэтгэл

Зарим хэлбэлзэлтэй үеийг эс тооцвол Монголын экспорт сүүлийн 20 жилд тасралтгүй өссөөр иржээ. 2000 онд экспорт 0.5 тэрбум ам.доллар байсан бол 2017 он гэхэд 6.2 тэрбум ам.долларт хүрч өсөөд байна (Зураг 1). 2009 онд дэлхийн санхүүгийн хямралаас үүдэлтэйгээр экспорт их хэмжээгээр буурсан боловч уул уурхайн бүтээгдэхүүний үнэ хурдан сэргэсэн тул жилийн дотор экспорт буцаад сэргэжээ.


Зураг 1. Экспорт, тэрбум ам.доллар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Гаалийн ерөнхий газар

Сүүлийн жилүүдэд Монголын эдийн засаг эрдэс түүхий эдийн үнийн хэлбэлзлээс шалтгаалан уул уурхайн огцом өсөлт, уналтын бүрэн мөчлөгтэй тулгарсан. Энэхүү хэлбэлзэл нь уул уурхайн салбарын нийт экспортод эзлэх хувьд нөлөөлсөн. Доорх зурагт сүүлийн хориод жилд уул уурхайн салбарын нийт экспортод эзлэх хувь хэрхэн өөрчлөгдөж ирснийг харуулав.

Зураг 2. Уул уурхайн ба уул уурхайн бус салбарын нийт экспортод эзлэх хувь




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Гаалийн ерөнхий газар

Сүүлийн хэдэн жилийн бага зэргийн хэлбэлзлийг эс тооцвол уул уурхайн салбарын нийт экспортод эзлэх хувь нь 2000 оноос хойш байнга өсөж байгаа бөгөөд энэ нь уул уурхайгаас хамааралтай байдлыг улам нэмэгдүүлж байна. Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ дээд цэгтээ хүрч, уул уурхайн салбарын үйлдвэрлэл огцом өссөн 2011, 2012 онд тус салбарын нийт экспортод эзлэх хувь хамгийн өндөр буюу 91.9% хүрсэн. Түүнээс хойш уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурч, үр дүнд нь уул уурхайн салбарын нийт экспортод эзлэх хувь буурсан. Гэхдээ 2017 онд энэ хувь 89.2 байгаа нь маш өндөр үзүүлэлт юм.

Энэ судалгаанд бид уул уурхайн салбарыг үндэсний статистикийн хорооны (ҮСХ) ангилснаар “эрдэс бүтээгдэхүүн”, “сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос” гэсэн 2 дэд салбараас бүрдэнэ гэж үзсэн. Доорх зурагт 2000 оноос хойш энэ 2 дэд салбарын уул уурхайн салбарт эзлэх хувь хэрхэн өөрчлөгдөж байгааг харуулав. Тухайлбал 2009-2012 онуудад “сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос” салбарын эзлэх хувь буурсан боловч 2012 оноос хойш эргээд өссөн байна. Гэхдээ энэ хувь нь 2000-аад оны эхэн үетэй харьцуулбал харьцангуй бага юм. Учир нь сүүлийн жилүүдэд эрдэс бүтээгдэхүүний салбар огцом өссөн.


Зураг 3. “Эрдэс бүтээгдэхүүн” ба “сүвд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос”-ны уул уурхайн салбарын экспортод эзлэх хувь



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Гаалийн ерөнхий газар

Энэ судалгаанд бид уул уурхайн бус салбарт гол анхаарлаа хандуулахын зэрэгцээ бодлого боловсруулах түвшний судалгааг чухалчлах болно. Экспортын салбарыг төрөлжүүлэх, ашигт малтмалын бүтээгдэхүүнээс хамааралтай байдлыг багасгахын тулд төр засгийн бодлого нь уул уурхайн бус салбаруудад чиглэх ёстой. Уул уурхайн бус экспорт сүүлийн арваад жил тасралтгүй өсөж байгаа ч энэ өсөлт уул уурхайн салбарын өсөлттэй харьцуулахад маш бага байгаа юм. Доорх зурагт 2000 оноос хойших уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортын хэмжээг харууллаа (Зураг 4).


Зураг 4. Уул уурхайн бус салбарын экспорт, сая ам.доллар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Гаалийн ерөнхий газар

Энд уул уурхайн бус салбарын экспортын хэлбэлзэлд хамгийн их нөлөө үзүүлж байгаа 8 бүтээгдэхүүнийг тодорхойлсон. Эдгээр бүтээгдэхүүн нь ноос ноолуур, нэхмэл, үндсэн төмөрлөг, машин тоног төхөөрөмж, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, арьс шир, арьс ширэн бүтээгдэхүүн, мах болон бусад малын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүн, хуванцар, каучук, түүгээр хийсэн зүйлс зэрэг болно. Эдгээр бүтээгдэхүүн 2017 онд уул уурхайн бус бүтээгдэхүүний 98.2 хувийг эзэлж байна (Зураг 5).

Зураг 5. Гол уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүний нийт уул уурхайн бус экспортод эзлэх хувь



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Гаалийн ерөнхий газар


Уул уурхайн бус бүтээгдэхүүнүүдийг ялгаварлалтай болон ялгаварлалгүй бүтээгдэхүүн гэж ангилдаг. Ялгаварлалгүй бүтээгдэхүүн нь бусад нийлүүлэгчдийн бүтээгдэхүүнтэй ижил төстэй бөгөөд чанарын хувьд ижил байдаг тул хооронд нь орлуулах боломжтой бүтээгдэхүүн юм. Үүнд эрдэс баялаг, үр тариа, элсэн чихэр гэх мэтийн ХАА-н бүтээгдэхүүн орно. Харин ялгаварлалтай бүтээгдэхүүн нь бусад бүтээгдэхүүнээсээ эрс ялгаатай, бусад бүтээгдэхүүнээр орлуулах боломжгүй бүтээгдэхүүн юм. Эдгээр нь ихэвчлэн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн болон үйлчилгээ байдаг. Тиймээс энэ хоёр төрлийн бүтээгдэхүүний экспортыг дэмжих бодлогын шийдвэрлэх асуудал нь өөр өөр байх ёстой.

Хөгжиж буй орнууд ерөнхийдөө анхдагч бүтээгдэхүүнийг экспортолдог. Тухайлбал, Волт Мартинкус, Карбалло (2010) нар Латин Америкийн орнуудад (Мексикээс бусад) нийт экспортод ялгавартай бүтээгдэхүүний эзлэх хувь 2007 онд 21.7 хувь, хөгжингүй орнуудад 62.3 хувь байгааг тооцжээ. Эдгээр судлаачид нь хөгжиж буй улсуудын эдийн засгийг цогц бүтээгдэхүүнүүдээр төрөлжүүлэх нь тэдэнд ихээхэн сорилт болдог хэмээн дүгнэжээ. Ялгаварлалтай бүтээгдэхүүнүүд нь шинж чанар болон чанараараа өөр

хоорондоо ялгаатай байдаг. Үүний улмаас ялгаварлалгүй бүтээгдэхүүний хувьд сайн ажилладаг үнийн дохиоллын функц ялгаварлалтай бүтээгдэхүүнд маш сул болж, зохион байгуулалттай худалдаа хийхэд хэцүү болгодог. Учир нь ялгаварлалтай бүтээгдэхүүний шинж чанарын талаарх мэдээллийн тэгш бус байдал нь ялгаварлалгүй бүтээгдэхүүнтэй харьцуулахад маш их байдаг. Энэ тохиолдолд экспортыг дэмжих бодлого нь мэдээллийн тэгш бус байдлыг арилгахад чиглэдэг.

Азийн хөгжлийн банк (АХБ)-ны худалдааны болон үйлдвэрлэлийн салбарын үнэлгээгээр 2004-2015 онд Монгол улсад үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртгийн өсөлт нь бодит ДНБ-ий өсөлтөөс харьцангуй бага байсан бөгөөд үүний ДНБ-д эзлэх хувь 2003 онд 10.0 хувь байснаа 2015 онд 5.7 хувь хүртэл буурсан. Үүнтэй адилаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүний бараа бүтээгдэхүүний экспортод эзлэх хувь нь 2003 оноос 2013 оны хооронд 37.9 хувиас 5.6 хувь хүртэл буурчээ. Доорх зурагт уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт дахь ялгаварлалгүй болон ялгаварлалтай бүтээгдэхүүний харьцангуй хувь хэмжээг харуулав.

Зураг 6. Уул уурхайн бус салбарын экспортод ялгаварлалгүй болон ялгаварлалтай бүтээгдэхүүний эзлэх хувь



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Гаалийн ерөнхий газар

2008-2017 оны хооронд ялгаварлалгүй бүтээгдэхүүний уул уурхайн бус экспортод эзлэх хувь дунджаар 91.1 хувь байсан бөгөөд сүүлийн хэдэн жилүүдэд алгуурхан өссөөр 2017 онд 91.9 хувьд хүрсэн.

Олон төрлийн ялгаварлалтай бүтээгдэхүүн экспортлох нь тухайн орны олон улсын зах зээл дэх өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж байдаг. Харамсалтай нь Монгол Улсын экспортын бүтээгдэхүүнүүдийн ихэнх нь ялгаварлалгүй бүтээгдэхүүн байдаг. Манай

улсын хувьд цөөн хэдэн төрлийн ялгаварлалтай¹ экспортын бүтээгдэхүүн байдаг бөгөөд энэ нь бусад хөгжиж буй орныхоос харьцангуй цөөн байдаг.

Зарим улс сүүлийн арван жилд экспортын бүтцэдээ аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэхэд гайхалтай дэвшил гаргасан (e.g., Artopoulos et al 2007). Энэ судалгаандаа бид эдгээр туршлага, Монголын экспортлогчдод үзүүлэх ач холбогдлын талаар авч үзэх болно.

Газар зүйн байршлаасаа шалтгаалаад Монгол Улсын гадаад худалдаа ихэвчлэн хоёр хөрш орон болох ОХУ, БНХАУ-тай хийгддэг. 2017 оны байдлаар БНХАУ-тай хийсэн худалдаа нийт гадаад худалдааны эргэлтийн 64 хувийг эзэлж байсан бол ОХУ-тай хийсэн худалдаа 12 хувь бол Европын Холбооны улсууд 11 хувь, Япон 4 хувь, Өмнөд Солонгос 2 хувь, АНУ 2 хувийг тус тус эзэлж байна. Манай улсын уул уурхайн бүтээгдэхүүний гол импортлогч орон БНХАУ тул 2000 оноос хойших гадаад худалдаанд БНХАУ-ын эзлэх жин ихэссээр байна.

Хүснэгт 1. Монголын нийт экспорт, түнш орнуудаар, хувиар

	2010	2011	2012	2013	2014	2016	2017
БНХАУ	84.4	91.4	91.9	86.7	87.8	82.0	85.0
ЕХ	4.7	2.5	1.8	7.0	9.7	14.7	11.8
Их Британи	2.3	0.4	0.3	4.7	6.9	7.9	10.7
Швейцар	0.1	0.4	0.2	0.1	0.5	4.9	0.0
Герман	0.8	0.3	0.4	0.4	0.3	0.9	0.2
Итали	1.1	1.0	0.7	1.2	0.9	0.7	0.7
Бусад	0.4	0.3	0.2	0.5	1.2	0.3	0.2
Америк	5.1	2.0	2.8	3.3	0.3	0.3	0.2
АНУ	4.9	1.9	2.7	3.2	0.0	0.1	0.1
Бусад	0.2	0.2	0.1	0.1	0.3	0.2	0.0
Ази (Хятадаас бусад)	2.6	2.0	1.5	1.1	1.2	1.6	1.7
ОХУ	2.7	2.0	1.8	1.4	1.1	1.2	1.1
Бусад орон	0.4	0.1	0.2	0.5	0.0	0.2	0.3
Нийт	100	100	100	100	100	100	100

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв, Гаалийн ерөнхий газар

¹ Бид дараах бүтээгдэхүүнүүдийг ялгаварлалтай бүтээгдэхүүн гэж үзлээ: “Зулмал хөвөн, эсгий ба нэхээсгүй материал; өвөрмөц ээрмэл; олс, оосор, дээс, татлага ба тэдгээрээр хийсэн зүйлс”, “Хивс болон нэхмэл дэвсгэр”, “Сүлжмэл хувцас ба хувцасны сүлжмэл тоног хэрэгсэл”, “Оёмол хувцас ба хувцасны оёмол тоног хэрэгсэл”, “Бусад нэхмэл бэлэн эдлэл; иж бүрдэл; хуучин хувцас ба хуучин нэхмэл эдлэл; хаягдал даавуу”, “Боловсруулсан арьс ширэн эдлэл; суран эдлэл ба тоног хэрэгсэл; аяны хэрэгсэл; эмэгтэй хүний цүнх”, “Үслэг арьс ба хиймэл үслэг арьс; тэдгээрээр хийсэн эдлэл”, “Бусад газар заагдаагүй, мал амьтны гаралтай бүтээгдэхүүн”. Бусад бүх уул уурхайн бус бүтээгдэхүүнийг ялгаварлалгүй бүтээгдэхүүн гэж үзэв.

Саяхныг хүртэл Монгол Улсын уул уурхайн бус экспортолдог зах зээл уул уурхайн бүтээгдэхүүний экспорттой харьцуулахад илүү өргөн хүрээтэй байсан. Сүүлийн жилүүдэд БНХАУ-ын уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт дахь хувь хэмжээ нэмэгдсээр байгаа. Европын холбооны улсууд (Герман, Итали, Их Британи) манай уул уурхайн бус бүтээгдэхүүний худалдааны гол зах зээл байж ирсэн. 2010 онд эдгээр улс нийлээд уул уурхайн бус экспортын 20.4 хувийг эзэлж байсан бол 2016 онд 13 хувьд хүрч буурчээ.

Хүснэгт 2. Эрдсийн бус экспорт, түнш орнуудаар, хувиар

	2010	2011	2012	2013	2014	2015	2016
БНХАУ	55.0	56.6	66.0	59.0	63.5	60.8	71.8
ЕХ	23.4	23.6	20.0	25.7	21.7	15.2	14.9
Герман	5.8	3.5	4.5	3.9	2.5	1.9	6.5
Итали	8.5	12.2	9.0	11.1	8.9	7.6	5.0
Их Британи	6.1	4.1	3.4	5.2	3.3	2.7	1.5
Франц	1.0	1.9	1.0	1.8	1.6	1.3	1.0
Бусад	1.9	2.0	2.1	3.6	5.4	1.8	1.0
Ази (Хятадаас бусад)	9.7	10.7	7.6	7.1	7.3	15.0	8.9
Япон	0.7	1.0	1.5	2.3	2.0	2.2	2.1
БНСУ	0.7	0.9	1.5	0.8	0.9	9.5	1.2
Тайвань	0.0	0.0	0.0	0.2	0.0	0.2	1.2
Сингапур	0.7	0.8	1.2	1.7	2.0	1.2	1.1
Бусад	7.6	7.9	3.4	2.2	2.3	2.0	3.3
Америк	0.9	1.2	1.1	1.3	2.1	3.2	1.7
АНУ	0.7	0.8	0.5	0.8	1.8	2.9	1.0
Ойрх Дорнод	2.6	1.1	2.2	2.4	3.6	2.7	1.1
ОХУ	8.1	6.5	2.7	2.3	1.6	2.5	1.3
Африк	0.1	0.1	0.5	0.6	0.2	0.0	0.1
Австрали, далайн орнууд	0.1	0.1	0.2	1.8	0.2	0.5	0.2
НИЙТ	100	100	100	100	100	100	100

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв, Гаалийн ерөнхий газар

2.2 Экспортыг дэмжсэн бодлогууд

Экспортыг дэмжих бодлого нь шинээр аж үйлдвэржсэн эдийн засагтай, ялангуяа Зүүн Азийн эдийн засгийг аж үйлдвэржүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэсэн. Япон, Өмнөд Солонгос, Тайвань, Сингапур зэрэг орон экспортыг дэмжих бодлогыг эртнээс хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд экспортыг эрчимтэй дэмжихийн тулд үндэсний дэд бүтцийн хүчирхэг төлөвлөлт болон төвлөрсөн нөөцийг дайчилсан. Тухайлбал, Өмнөд Солонгосын Засгийн газар 5 жилийн хөгжлийн төлөвлөгөөг баталж, дунд болон урт хугацаатай хөрөнгө оруулалтыг экспортын баримжаатай үндэсний үйлдвэрлэлүүдэд таатай нөхцөлтэйгөөр олгохын тулд улсын тусгай банкныг (Солонгосын Хөгжлийн

Банк) байгуулсан. Энэ банк гадаадын санхүүжилт болон засгийн газрын бага зэрэг эх үүсвэрээр санхүүждэг байсан (Канг, 2003).

Нөгөө талаас, олон судалгаанд 1960-аад оны үеийн Латин Америкийн орнуудад хэрэгжиж байсан импортыг орлох бодлоготой холбоотой олон алдааг онцлон тэмдэглэсэн байдаг. Түүнээс хойш зарим улс нь худалдааны бодлогоо бүс нутагтаа экспортлогчид руу амжилттай чиглүүлсэн. Саяхан Зүүн болон Төв Европын зарим улс Эдийн засгийн харилцан туслах зөвлөл (ЭЗХТЗ) тарснаас хойш худалдааны чиг баримжаагаа амжилттай сольж хүчирхэг аж үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортлогчидтой болсон.

1997 онд Дэлхийн худалдааны байгууллагад элссэнээс хойш Монгол улс нь худалдааны чөлөөт нөхцөлийг идэвхтэй дэмжсээр байгаа. Тухайлбал, Засгийн Газраас ихэнх импортын бараанд 5 хувийн татвар ногдуулсан. Зарим экспортын бараа онцгой албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдсөн.

Дотоодын зах зээлийн багтаамж багатай, их хэмжээний байгалийн болон бусад баялагтай Монгол Улсын хувьд тогтвортой эдийн засгийн өсөлтийг хангах, урт хугацааны хөгжлийн асуудлуудыг шийдэхийн тулд гадаад зах зээл рүү хандсан бодлого баримтлах нь зайлшгүй. Энэ асуудал уул уурхайн салбарын идэвхжил, уул уурхайн бүтээгдэхүүний экспортоос хэт хамааралтай байх, гадаад худалдааны хэлбэлзэлтэй холбоотойгоор улам хурцаар тавигдаж байна. Экспортыг илүү идэвхтэй дэмжих ялангуяа уул уурхайн бус экспортыг дэмжих нь зүйтэй гэсэн хандлага нэмэгдэж байгаа. Үүний үр дүнд саяхан Засгийн газраас экспортын баримжаатай өсөлтийг ойрын жилүүдийн хөгжлийн тэргүүлэх чиглэл болгон зарлаж, үндэсний экспортыг дэмжих бодлогын эхний алхмуудыг хийсэн.

2.2.1 Экспортыг дэмжих үндэсний бодлогууд

1998 онд Засгийн Газраас экспортыг дэмжих бодлогын анхны оролдлогыг хийсэн. Засгийн газрын "Экспортын үйлдвэрлэлийг дэмжих" (158 тоот) тогтоол нь ашигт малтмал, хөдөө аж ахуйн экспорт, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн байсан. Тэрхүү тогтоолд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг Үндэсний (экспортын) зөвлөл удирдана гэж заасан хэдий ч энэ зөвлөл байгуулагдаагүй бөгөөд тогтоол 2002 онд цуцлагдсан. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд маш бага хөрөнгө зарцуулсан тул дээрх Засгийн газрын тогтоол гадаад худалдаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй гэж үзэж болох юм. Ерөнхийдөө бид уул уурхайн салбарын экспортын хурдацтай өсөлт нь уул уурхайн шинэ орд газруудыг нээж илрүүлэх болон гадаад хүчин зүйлээс хамааралтай гэж үзэж байна. Гэвч бусад салбарт төдийлөн өөрчлөлт ороогүй.

2008 онд Монгол Улсын Их хурлаас батлагдсан Монгол Улсын Мянганы Хөгжлийн зорилтод суурилсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д экспортоор баримжаалсан өсөлтийг засгийн газрын тэргүүлэх чиглэл болгон зарласан. Тухайлбал, энэ стратегийн баримт бичигт 2 дахь үндэсний тэргүүлэх чиглэл нь “Экспортын баримжаатай, хувийн

хэвшилд түшиглэсэн өндөр технологи, үүний дотор мэдээлэл, харилцаа, био, нано технологи, транзит тээвэр, логистик, санхүүгийн зуучлалын үйлчилгээ, уул уурхай, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг гүн боловсруулахад суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй хөгжүүлж, тогтвортой, мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгоно” хэмээн тунхагласан (Бүлэг 3).

Уул уурхайн салбарыг мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгоход шаардлагатай санхүүгийн эх үүсвэр, капиталын хуримтлалыг бүрдүүлэх гол эх үүсвэр болно гэж үзэж байгаа. Цаашилбал, уул уурхайн орлого нь бусад экспортын салбарыг хөгжүүлэхэд шаардагдах бүс нутгийн эрчим хүчний сүлжээ, хоёр хөрштэйгөө холбогдох, цаашлаад Европ, бусад Азийн орнуудтай худалдаа хийхэд шаардлагатай дэд бүтцийг барьж байгуулахад ашиглах нь зүйтэй.

2013 онд Засгийн Газраас хамгийн анхны харьцангуй цогц экспортыг дэмжих хөтөлбөр болох 2013-2018 онд хэрэгжүүлэх “Экспортыг дэмжих хөтөлбөр”-ийг баталсан (Засгийн Газрын 2013 оны 6 сарын 6-ы 239-р тогтоол). Үүнээс өмнөх экспортыг дэмжих Засгийн газрын үйл ажиллагаа нь хөнгөн үйлдвэр, мал аж ахуй, хөдөө аж ахуй, дэд бүтцийн хөгжил, ЖДҮ-ийн хөгжил зэрэг аж үйлдвэрийн тусгай бодлогуудаар дамжин хэрэгжиж байсан. Эдгээрийг салбарын шинжилгээ бүлэгт дэлгэрэнгүй авч үзэв.

Энэ хөтөлбөрийн зорилго нь экспортлогчдыг шаардлагатай зээл, зээлийн баталгаа, худалдааны санхүүжилт болон даатгалын үйлчилгээгээр хангах, шинэ зах зээлд нэвтрэхэд тусалж, нийлүүлэлтийн шаардлагуудыг багасгаж, экспортын өрсөлдөх чадварыг сайжруулах замаар экспортыг бэхжүүлэх, “Нэг цонхны үйлчилгээ”-г нэвтрүүлж гадаад худалдааг хөнгөвчлөх юм. Мөн энэ хөтөлбөр нь экспортыг нэмэгдүүлж, экспортын төрөлжилтийг дэмжиж, дунд хугацаанд уул уурхайн бус салбарын экспортыг дэмжих замаар нийт экспортын 1/3-д хүргэх зорилготой байгаа.

Шигтгээ 1. Экспортыг дэмжих хөтөлбөр, 2013-ын үндсэн чиглэлүүд

Зорилго:

Монгол Улсын экспортын орлогыг нэмэгдүүлэх, гадаад худалдааны бүтцийн зохистой байдлыг хангах, экспорт, импортыг орлох дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, экспортын үр ашигтай санхүүжилтийг хангах, экспортын болон экспортыг дэмжих импортын лизингийн үйлчилгээ үзүүлэх байгууламжийн тогтолцоог үүсгэн хөгжүүлэх.

Зорилт:

1. Экспортыг нэмэгдүүлэх буюу экспортлогчийг шинэ зах зээлд нэвтрэх, байр сууриа бэхжүүлэхэд зах зээлийн судалгаа, маркетингийн зөвлөгөө өгөх, экспортыг дэмжих импортын лизингийн үйлчилгээ үзүүлэх байгууламжийн тогтолцоог бүрдүүлэх;
2. Экспортын болон импортыг орлох дотоодын үйлдвэрлэлийн санхүүжилтийн оновчтой тогтолцоо, байгууламжийн орчныг бүрдүүлэх;
3. Экспортлогчийн санхүүгийн болон бусад зардлыг бууруулах байгууламжийн орчныг бүрдүүлэх;
4. Экспортын "нэг цонх"-ны бодлогыг хувийн хэвшлийн санаачилга, манлайллыг дэмжих замаар хэрэгжүүлэх;
5. Хил гаалийн үр ашигтай, шуурхай үйлчилгээг хангах, тарифын бус зохицуулалтын аргачлал боловсруулж нэвтрүүлэх, экспортын тээврийн тогтолцооны үр ашгийг дээшлүүлэх.

Санхүүжилтийн эх үүсвэр:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалт, Монгол банкны бодлогын шинж чанартай богино хугацааны зээлийн эх үүсвэр, олон улсын банк, хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламж, гадаад дотоодын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт.

Хөтөлбөрийн үр дүн:

- Гадаад худалдааны тэнцэл алдагдалгүй болно, дотоодын мөнгөн хуримтлал, валютын нөөц нэмэгдсэн байна.
- Экспортын бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэж, бүтцэд өөрчлөлт орон эрдэс баялгийн бус экспортыг 5 жилийн хугацаанд 3 дахин нэмэгдүүлж, нийт экспортын 21%-аас доошгүй хэмжээнд хүргэсэн байна.
- Зохих түвшний стандартыг нэвтрүүлэх, түүнд нийцсэн тэргүүний, дэвшилтэт шинэ технологийг нутагшуулах, технологи дамжуулалтыг эрчимжүүлэх, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай, чанартай, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөл сайжирсан байна.
- Экспортын үйл ажиллагааг шинэ түвшинд хүргэж, "Нэг цонх"-ны бодлогоор хэрэгжүүлдэг болсон байна.
- Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа дотоодын аж ахуйн нэгжүүд санхүүгийн хувьд бэхжиж, эрсдэл даах чадвар нэмэгдсэн байна.

2016 онд Засгийн Газраас “Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал-2030”-д суурилж “Экспортыг Дэмжих Үндэсний хөтөлбөр”-ийг баталсан (2016 оны 4 сарын 18-ны Засгийн газрын 211-р тогтоол). Шинэ хөтөлбөр нь өмнөх хөтөлбөрийн сайжруулсан хувилбар байсан бөгөөд 2016-2020 онд хэрэгжих юм. Энэ хөтөлбөр нь урт хугацаанд уул уурхайн бус экспортыг дэмжих зорилготой ба гол зорилт нь инноваци, мэдлэгт суурилсан экспортын бүтээгдэхүүн, түүний үйлдвэрлэлийг дэмжих замаар экспортыг төрөлжүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулах юм.

Одоогийн байдлаар энэ хөтөлбөрийн албан ёсны үнэлгээ хийгдээгүй байгаа. Блүүмберг Монголиа зэрэг зарим мэдээллийн сайтууд хөтөлбөрийн гүйцэтгэл 18 хувьтай байгаа гэж дурдсан бөгөөд албан ёсны тоон мэдээлэл олдоогүй. Монгол Улсад өмнөх хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг хийлгүйгээр дараагийн хөтөлбөрийг баталдаг жишээ олон байдаг ба энэ тохиолдолд мөн хэрэгжилтийн үнэлгээ хийгээгүй байна.

Шигтгээ 2. Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөр-2016 -ын үндсэн чиглэлүүд

Зорилго:

Инноваци, мэдлэг шингэсэн дэвшилтэт техник, технологид суурилсан боловсруулах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах, экспортыг төрөлжүүлэх замаар Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангахад дэмжлэг үзүүлэх

Зорилтууд:

1. Экспортын орлогыг нэмэгдүүлж, экспортын бүтцийг төрөлжүүлэхийг дэмжих чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
2. Экспортыг дэмжих “нэг цонх”-ны бодлого хэрэгжүүлэх, логистик, дэд бүтцийг хөгжүүлэх;
3. Экспортын чиг баримжаатай дотоодын үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх
4. Экспортын шинэ зах зээлд нэвтрэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
5. Боловсруулах үйлдвэрлэлд байгаль орчинд ээлтэй, түүхий эд материалын хэмнэлттэй, үр ашиг бүхий дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, нутагшуулах, инноваци, мэдлэг шингэсэн, уул уурхайн бус үйлдвэрлэлийн кластерийг дэмжих замаар экспортыг төрөлжүүлэх.

Санхүүжилтийн эх үүсвэр:

- Улсын төсөв, Хөгжлийн банкны санхүүжилт, хандивлагч орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагын зээл, тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт.

Хөтөлбөрийн үр дүн:

- Экспортыг төрөлжүүлж, уул уурхайн бус салбарын экспортыг нийт экспортын 30 хувьд хүргэнэ;
- Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэнэ;
- Арьс шир, ноос, ноолуур, хөдөө аж ахуйн бусад түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60 хувьд хүргэж, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн аж үйлдвэрлэлийн салбарын экспортын орлогыг жилийн 1 тэрбум ам.долларт хүргэнэ;
- Экспортыг “нэг цонх”-оор зохицуулах боломж бүрдэж хэрэгжинэ.

2013 онд батлагдсан хөтөлбөр нь гол төлөв арьс шир, ноос ноолуурын төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжихээр төлөвлөсөн байсан бол 2016 оны хөтөлбөр нь өмнөх хөтөлбөртэй харьцуулахад арай урт хугацаанд чиглэсэн, цөөн боловч

санхүүгийн бус арга хэрэгслүүдийг ашигласан, хөнгөн, хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх зорилготой байжээ.

2.2.2 Экспортыг дэмждэг байгууллагууд – институтийн бүтэц

Улс орон болгон экспортыг дэмждэг өөр өөр төрлийн байгууллагатай байдаг. Тухайлбал олон нийтийн, хувийн, эсвэл холимог төрлүүд байж болно. Эдгээр байгууллага нь гадаад худалдааг хөгжүүлэхдээ тодорхой нутаг дэвсгэр дээр эсвэл тодорхой салбар/бүтээгдэхүүн дээр төвлөрсөн өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр байгууллагыг судлаачид өөр загваруудаар ангилсан байдаг. Жишээлбэл, Жордана тэргүүтэй судлаачид (2010) дөрвөн хэлбэрийг санал болгодог: шаталсан олон нийтийн, төвлөрсөн бус, олон ургалч, хувийн.

Шаталсан олон нийтийн загварт улсын экспортыг дэмжих бодлогыг хэрэгжүүлдэг ганц байгууллага байдаг бол бусад байгууллага нь хоёрдогч үүрэг гүйцэтгэдэг. Төвлөрсөн бус загварт хэд хэдэн олон нийтийн (эсвэл хагас олон нийтийн) байгууллагууд байдаг бөгөөд хэн ч давамгайлахгүй. Тэдэнд газар нутгийн болон үйл ажиллагааны хүрээг тодорхой зааж өгсөн тул тэд бие биетэйгээ шууд өрсөлддөггүй. Тиймээс, хамтран ажиллаж, зохицуулж болно. Олон ургалч шинжтэй загварын хувьд олон талт, хувийн хэвшлийн шинжтэй экспортыг дэмждэг байгууллагууд байдаг бөгөөд тэдгээр нь янз бүрийн үүргийн дагуу ажилладаг. Тэд хуваагдсан гэсэн ч мэргэшсэн байдаг тул өрсөлдөгчид болон хамтран ажиллагсдын аль аль нь байж болно. Хувийн загвар нь хувийн экспортыг дэмжих байгууллагын давамгайлсан тохиолдолтой төстэй бөгөөд хувийн санаачилга, олон нийтийн байгууллагын санаачилга нь зөвхөн хоёрдогч үүрэг гүйцэтгэдэг.

Жордана нарын судлаачид дээрх зохион байгуулалтын онцлогоос хамаарч амжилтад хүрэх байдал янз бүр байдгийг харуулсан. Үүнээс гадна, бодит зохион байгуулалт нь хэдэн арван жил бүрэлдсэн улс орны өвөрмөц институтийн хөгжлийн үр дүн байж болох юм. Энэ нь Латин Америкийн худалдааг дэмжих урт хугацааны түүхээс харагдаг. Экспортыг дэмжих үйл ажиллагааны үр дүн нь экспортыг дэмжих байгууллагын үйл ажиллагаа, ажиллах хүч, төсөв, улс орондоо эсвэл гадаадад байдаг эсэх болон тэр байгууллага ямар төрлийн үйлчилгээ үзүүлж байгаагаас хамаардаг.

Монголын хувьд экспортыг дэмжих төвлөрсөн бус аргыг ашиглаж байна. Монгол дахь гадаад худалдааны бодлогын хэлбэр нь засгийн газрын агентлагууд, төрийн бус байгууллагууд, хоёр талын болон олон талт санхүүгийн байгууллагуудыг багтаасан хэд хэдэн байгууллагын бүрдэл юм. Сүүлийн арван жилийн хугацаанд Засгийн газрын гадаад худалдааг дэмжих үүрэг нь янз бүрийн яамдад шилжсээр иржээ.

Хүснэгт 3. Засгийн газрын гадаад худалдааны чиг үүрэг

Гадаад худалдааны чиг үүрэг		Экспортыг дэмжих арга хэмжээ
2004-2008	Үйлдвэр, худалдааны яам	Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны газар
		Хүнс, хөдөө аж ахуйн яам
		Гадаад харилцааны яам
2008-2012	Гадаад харилцааны яам	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
		Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо
2012-2014	Гадаад харилцаа, Эдийн засгийн хамтын ажиллагааны яам	Хөдөлмөрийн яам (ЖДҮ хөгжүүлэх сан)
		Эдийн засгийн хөгжлийн яам
		Гадаад харилцааны яам
2014-2016	Аж үйлдвэрийн яам	Хүнс, хөдөө аж ахуйн яам
		Гадаад харилцааны яам
2016 оноос	Гадаад харилцааны яам	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
		Үндэсний хөгжлийн газар

Эх сурвалж: Засгийн газрын бүтцийн талаарх хуулиуд, УИХ-ын тогтоолууд

2004-2008 онд уг үүрэг нь Үйлдвэр, худалдааны яам болон Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг (ГХОГХА) хяналтад байсан. ГХОГХА-ийн үйл ажиллагаа нь гол төлөв гадаадын хөрөнгө оруулалтад чиглэгдэж байв. Агентлагийн экспортыг дэмжих үйл ажиллагаа нь ажиллах хүч болон санхүүжилтийн хувьд дутагдалтай байсан (Gotz-Debnicka & Baigalmaa, 2014).

Агентлаг 2008 онд татан буугдсан бөгөөд, үлдсэн ажилчид нь чиг үүргийн хамт Гадаад харилцааны яам, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо уруу шилжсэн. Түүнээс хойш Засгийн газрын худалдааг дэмжих чиг үүрэг нь яам агентлагуудын салж нийлэх үйлдлээс болж янз бүрийн яам, агентлагуудад шилжсээр ирсэн (Хүснэгт 3).

Одоогийн Засгийн газрын үйл ажиллагаанд Гадаад харилцааны яам нь гадаад худалдааны бодлогыг хариуцдаг ерөнхий агентлаг юм. Гадаад харилцааны яамны Олон Улсын Худалдаа, Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны хэлтэс нь худалдааны бодлогыг ерөнхийд нь хянах, экспортыг дэмжих үйл ажиллагааг хариуцдаг. Гадаадад дипломат

төлөөлөгчийн газар нь эдийн засгийн асуудал хариуцсан үүрэг хүлээдэг бөгөөд ГХЯ-д захирагддаг боловч Монгол улсын экспортыг дэмжихэд нэг их оролцдоггүй. Эдгээр төлөөлөгчийн Гадаад худалдааг дэмжихэд гүйцэтгэсэн үүрэг нь монголын компаниудыг үзэсгэлэн, үзэсгэлэнд оролцоход нь тусалдаг. Тэдний зарим нь гадаадын зах зээлийн талаар мэдээлэл цуглуулдаг. Эдийн засгийн чиглэлийн үүрэг бол дипломат төлөөлөгчийн газрын хувьд харьцангуй шинэ чиг үүрэг юм. Гэсэн хэдий ч ГХЯ-ны гадаад худалдааг дэмжих чиг үүрэгт энэ газрыг нөлөө өсөж байгаа.

2013 оноос өмнө хийгдсэн экспортыг дэмжих бодлого нь тодорхой салбаруудад чиглэж байсан. Экспортыг дэмжих арга хэмжээний дийлэнх хэсгийг тодорхой салбаруудад чиглүүлж, ЖДҮ-ийг хөгжүүлэх сан, Мал хамгаалах сан, Газар тариалан хөгжүүлэх сан гэх мэт сангуудаар дамжуулан дэмжлэг үзүүлж байсан. Эдгээр сангууд нь Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, хөдөлмөр зэргийг хариуцдаг яамдад харьяалагдаж байжээ. Эдгээр яамны чиг үүргүүд сүүлийн арван жилд олон удаа өөрчлөгдсөн. Жишээлбэл, ЖДҮ хөгжүүлэх сан анх Хүнс, хөдөө аж ахуйн яаманд байгуулагдаж, дараа нь Үйлдвэр, худалдааны яам, Хөдөлмөрийн яам, тэгээд дараа нь Үйлдвэрийн яам, эцэст нь (одоогоор) Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны (ХХААХҮЯ) харьяанд шилжсэн. Аж үйлдвэрийн бодлогын чиг үүргийг 2016 онд хүнд үйлдвэрлэлийн салбар болон хөнгөн үйлдвэрлэл гэж хуваасан (Уул уурхайн яам, Хүнд үйлдвэрлэлийн яам). Хөнгөн үйлдвэрлэлийн чиг үүрэг нь хүнс болон хөдөө аж ахуйн бодлоготой хослон ХХААХҮЯ-д шилжсэн. Энэхүү бүтцийн өөрчлөлтийг хийснээр экспортыг дэмжих бодлогод энэ яам гол үүрэг гүйцэтгэх болсон. Сүүлийн үеийн экспортыг дэмжих хөтөлбөрүүд нь экспортыг дэмжих бодлогыг төвлөрүүлэхийг оролдож байна. 2016 оны Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөрт Гадаад хэргийн яамыг хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах гол байгууллага хэмээн зарласан.

Зарим төрийн бус байгууллагууд экспортыг дэмжих үйл ажиллагаанд оролцдог. ТББ-уудын дунд хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг нь Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ) юм. Тус танхим 3000 гаруй гишүүдтэй бөгөөд сургалт, бичиг баримт болон бизнесийн харилцаатай холбоотой мэдээллээр хангах зэрэг экспорттой холбоотой үйлчилгээг үзүүлдэг. Тус танхим нь хөдөө орон нутагт 12 салбар, гадаадын 30 оронд төлөөлөгчийн газартай. Түүний дотор Хятад, Орос, АНУ-д хэд хэдэн төлөөлөгчийн газартай. Тус танхим нь гадаад худалдааны танхимын техникийн туслалцааг авчээ.

Монголын Ноос, Ноолуурын Нийгэмлэг, Монголын Нэхмэлийн Үйлдвэрлэгчдийн Холбоо, Махны Ассоциаци гэх мэт салбарын хэд хэдэн холбоод байдаг. Тэдний зорилго бол тухайн салбарт байгаа саад бэрхшээлийг тодорхойлох, семинар, бага хурал, сургалт зохион байгуулах замаар саад бэрхшээлийг арилгах, Засгийн газартай харилцахдаа өөрсдийн гишүүдийн төлөөлөл болох лобби бүлгийг ажиллуулах юм. Гэсэн хэдий ч, тэдний экспортыг дэмжих үйл ажиллагаа нь хязгаарлагдмал байгаа буюу тэд хэд хэдэн олон улсын худалдааны яармагт оролцож салбарын үйлдвэрлэгчдийг дэмжиж байна. Монголын Ноос ноолуурын Холбоо, Монголын Арьс Үйлдвэрлэгчдийн Холбооны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлд экспортыг дэмжих үйл ажиллагааг тусгасан байдаг. Тус

холбоо нь АХБ, Сангийн яам, (хуучин) Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамтай хамтран 2012-2020 оны хооронд “Арьс ширэн үйлдвэрийн салбарын сэргээн босголтын төсөл” -ийг хэрэгжүүлж байна.

Олон улсын санхүүгийн байгууллагууд олон тооны худалдаатай холбоотой төслүүдийг санхүүжүүлдэг. АХБ хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслүүдийг санхүүжүүлж, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт жижиг дунд үйлдвэрлэгчдэд хөнгөлөлтэй зээлийг олгож байна. Тухайлбал, "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төсөл" нь хөдөө аж ахуйн салбарын экспортын бүтээгдэхүүний чанар, стандартыг боловсронгуй болгох, хөдөө аж ахуйд суурилсан бизнес эрхлэгчдийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэхэд туслах зорилготой юм.

2017 онд Дэлхийн банк, Сангийн яам нь "Экспортыг хөгжүүлэх төсөл" -ийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ төсөл нь экспортын чадавхыг бэхжүүлж, гадаадын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх замаар жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих зорилготой. Төсөл нь дараах 3 хэсэгт хуваагдана: (I) Хөдөө аж ахуйн давхар даатгалын хамтарсан компанийг бэхжүүлэх замаар экспортын шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, (II) сургалтын хөтөлбөр, санхүүжилтийг зуучлах замаар экспортлогчдын (ирээдүйд бүтээгдэхүүнээ экспортлох боломжтой үйлдвэрлэгчид) өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, (III) экспортын төрөл бүрийн үйлчилгээнүүдийг нэвтрүүлэх.

Хоёр талт агентлагууд нь уул уурхайн бус экспортыг дэмжих үйл ажиллагаанд оролцдог. Монгол Улсад түгээмэл үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд бол Германы хөгжлийн агентлаг GIZ (хуучин GTZ), Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг (JICA), АНУ-ын ОУХА болон бусад цөөхөн хэдэн байгууллагууд юм. Эдгээр агентлагуудын оролцоо нь төвлөрсөн бус, байнгын бус байдаг. GIZ болон JICA байгууллагуудын хэрэгжүүлдэг төслүүд нь ЖДҮ-ийн хөгжилд гол анхаарлаа хандуулдаг. JICA нь жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилготойгоор хоёр үе шаттай зээлийн төсөл хэрэгжүүлсэн бөгөөд Монголын арилжааны банкнуудаар дамжуулан ЖДҮ-үүдэд бага хүүтэй зээл олгосон. Энэ төслийн 2 үе шатанд нийт 8 ба 5 тэрбум иений зээл олгожээ.

Жижиг бизнесийг хөгжүүлэх санаачилгын хүрээнд ГХА-аас мод боловсруулах, барилга, арьс шир, үслэг эдлэл, хэвлэх, ноос, ноолуур, эко-аялал жуулчлал зэрэг сонгогдсон салбаруудын ЖДҮ-дэд дэмжлэг үзүүлсэн. Тухайлбал, ЖДҮ-ийн экспортын бодлого болон Европын Холбооны улсууд руу гаргах махны экспорт, ноолуурын экспортын чадавх зэрэг экспортын асуудлуудад техникийн туслалцаа үзүүлсэн. Үүнд өргөн хүрээний сургалт болон олон улсын худалдааны үзэсгэлэн, үзэсгэлэнд оролцох оролцоог дэмжих хөтөлбөрүүд багтсан байдаг.

АНУ-ын ОУХА-ын санхүүжилттэй “Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадварын төсөл” нь хувийн хэвшлийн өсөлтийн орчин болон илүү өрсөлдөх чадвартай салбар, үйлдвэрлэлийг бие болгоход туслах зорилготой юм. Энэ төсөл нь ноолуур, аялал жуулчлал, мах, арьс ширний үйлдвэрт чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. АНУ-ын ОУХА, ГХА-ийн төслүүд нь Берлин хот дахь Монголын ноолуурыг түгээх төвийг

байгуулахад тусалсан ба энэ төв Монголын ноолуурын компаниуд болон арилжааны банкнаас санхүүждэг. Энэ төсөл нь сонгогдсон салбаруудын зах зээлийг тандаж, компаниудад гадаадын үзэсгэлэн яармагт өөрсдийгөө хэрхэн танилцуулах тал дээр зөвлөгөө өгч, компаниудын танилцуулгыг хэвлэдэг.

Дүгнэж хэлэхэд, Монголын гадаад худалдааны бодлогын хяналт, экспортыг дэмжих үйл ажиллагаа нь янз бүрийн байгууллагад харьяалагддаг. Энэ төрлийн бодлогын хяналт нь яамдын чиг үүргийн өөрчлөлтөөс болж хэд хэдэн яамдын дунд шилжсэн бөгөөд энэ нь бодлогын тасралтгүй байдал, тууштай байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй. Олон улсын туршлагаас харахад экспортыг дэмжих стратегийг тууштай хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой байдаг. Жордана нарын судалгаанд (2010) тэмдэглэснээр "институцийн гэнэтийн болон эрс өөрчлөлт, тухайлбал 1990-ээд оны үед зарим улс оронд ажиглагдсанчлан стратегийн огцом тасалдал нь бодлогын үр дүнтэй байдалд сөргөөр нөлөөлөх магадлалтай" гэжээ (97). Бид Монгол Улсын зарим институцийн тасалдал болон өөрчлөлтийн талаарх мэдээллийг олж авсан. Ялангуяа, гадаад худалдааг хянах чиг үүргийг олон яамдын хооронд шилжүүлснээр бодлогын тогтвортой байдал, бэлтгэгдсэн боловсон хүчин, туршлагаа алдах магадлалтай болгодог. Энэ бодлогод хувийн хэвшлийнхэн оролцдоггүй бөгөөд бусад төрийн бус байгууллагууд цөөн бөгөөд үйл ажиллагаа нь сул байдаг. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын гадаад дахь төлөөлөгчөөс өөр бусад гадаадад суудаг төлөөлөгчид ховор байдаг. Дипломат төлөөлөгчийн газрууд экспортыг дэмжихэд бага үүрэг гүйцэтгэдэг хэвээр байна. Санхүүгийн болон хүний нөөц хомсдолтой, үйл ажиллагааны хүрээ хязгаарлагдмал байна.

Гадаадад суудаг төлөөлөгчид хямд санхүүгийн эх үүсвэр, чадавхыг бий болгох хэлбэрээр санхүүгийн болон техникийн туслалцаа үзүүлдэг. Гэсэн хэдий ч эдгээр хүчин чармайлт нь ерөнхийдөө экспортын салбараас илүүтэйгээр жижиг бизнесийн салбарт илүү чиглэгддэг. Экспортлогчдод үзүүлж буй дэмжлэг нь цөөн хэдэн салбарт чиглэсэн, түр зуурын шинжтэй байдаг.

2.2.3 Экспортыг дэмжих бодлогын арга хэрэгсэл

Экспортыг дэмжих бодлогын арга хэрэгслүүд нь санхүүгийн болон санхүүгийн бус арга хэмжээнүүдээс бүрддэг. Экспортыг дэмжих уламжлалт бодлого нь ерөнхийдөө санхүүгийн урамшуулал, хөнгөлөлттэй зээлийн багц, экспортлогчдод үзүүлж буй шууд дэмжлэгээс бүрддэг бөгөөд эдгээр нь Латин Америк, Зүүн Азид өргөнөөр хэрэглэгдэж байсан. Гэсэн хэдий ч, энэ төрлийн ихэнх бодлого үр дүнгүй гэдэг нь батлагдсан бөгөөд хүнд сурталтай үйл ажиллагаа явуулдаггүй байгууллагуудыг бий болгодог. Энэ нь Латин Америкийн орнуудын жишээнээс илхэн харагддаг бөгөөд энэ бүс нутагт 1950-1960д оны үед хэрэгжиж байсан экспортыг дэмжих бодлого нь бараг бүх оронд амжилтгүй болсон. Эдгээр улсын ихэнх нь 1990-ээд оны дунд үеэс экспортыг дэмжих бодлогыг дахин хэрэгжүүлж эхэлсэн ба энэ бодлого нь өмнөх бодлогоос өөр байсан. Тэд

төгс бус мэдээллээс үүдсэн зах зээлийн алдааг засах зорилготой байсан. Хоёр төрлийн мэдээллийн тэгш бус байдал байдаг: (i) гадаадад бизнес эрхлэх боломжийг хайж олохтой холбоотой дотоодын экспортлогчдоос гарах зардал ихтэй, (ii) гадаадын улс орнуудын худалдан авагчийн экспортын бүтээгдэхүүний чанарын талаарх мэдээлэл. Тиймээс "эдгээр бодлого нь мэдээллийн тэгш бус байдлыг арилгах, санхүүгийн болон зээлийн арга хэрэгслийн шууд үүргийг сулруулахад компаниудад дэмжлэг үзүүлдэг (Жордана нар 2010). Гол асуудал нь ялгаварлалтай бүтээгдэхүүнийг таниулахад зардал өндөр байдаг.

Монголын Засгийн газрын бодлогууд экспортыг дэмжих уламжлалт загварыг дагаж мөрддөг бөгөөд эдгээр нь гол төлөв санхүүгийн урамшуулал байдаг. Тухайлбал экспортлогчдод хөнгөлөлттэй зээл олгох, экспортын зарим бүтээгдэхүүнийг НӨАТ-аас чөлөөлөх, экспортлогчдод чанартай түүхий эд материал нийлүүлдэг малчин өрхүүдэд мөнгөн урамшуулал олгох, экспортлогчдод олон улсын зах зээл дээр эрсдэлийг бууруулахад Засгийн газраас баталгаа олгох зэрэг үйл ажиллагаанууд байдаг. Эдгээр арга хэмжээг улсын төсөв болон Монгол улсын Хөгжлийн банкнаас шууд санхүүжүүлж, улсын болон хувийн төслүүдэд зориулсан хөнгөлөлттэй зээлийг олгодог.

Доорх хэсэгт салбаруудад олгож байгаа экспортыг дэмжих санхүүгийн арга хэрэгслүүдийг тодорхойллоо.

Ноос, ноолуур болон нэхмэлийн салбар

- 2011 оноос үндэсний боловсруулах үйлдвэрт ноос, ноолуур бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгож байгаа.
- 2011-2014 онд Засгийн Газраас үндэсний ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлүүдийг олгож байсан.
- 2013, 2015 онд Засгийн газраас экспортыг дэмжих, импортыг орлох бүтээгдэхүүнүүдэд зээл олгосон бөгөөд үүний хүрээнд нэхмэлийн салбарын үйлдвэрүүдэд зээл олгосон.
- 2015 оноос хойш экспортод гаргах хэдэн төрлийн ноос, ноолууран бүтээгдэхүүний НӨАТ-ыг тэглэсэн.
- Засгийн газраас ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор ноолуурын үйлдвэрлэлийн гадаад зах зээлийн эрсдэлээс сэргийлэхийн тулд 100 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан.

Арьс шир, арьс ширэн эдлэлийн салбар

- 2012-2014 онд арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгосон.

- 2012 оноос үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгож байна.
- 2015 оноос экспортод гаргах хэдэн төрлийн арьс ширэн бүтээгдэхүүний НӨАТ-ыг тэглэсэн.

Үндсэн төмөрлөгийн салбар

- 2015 онд Засгийн газраас экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор металлургийн үйлдвэрүүдэд зээл олгосон.

Машин тоног төхөөрөмжийн салбар

- 2015 онд Засгийн газраас экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор металл боловсруулалт, машин үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрүүдэд зээл олгосон.

Мах болон амьд малын гаралтай бүтээгдэхүүний салбар:

- 2015 онд Засгийн газраас экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд зээл олгосон.
- 2016 оноос хойш Засгийн газраас махны экспортыг нэмэгдүүлэхийн тулд "Мах" хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа боловч одоогийн байдлаар энэ төрлийн үйлдвэрлэлд зээл олгоогүй байна.

Хүнсний бүтээгдэхүүний салбар

- 2013 онд Засгийн Газраас үйлдвэржилтийг дэмжих бодлогын хүрээнд Хүлэмжийн аж ахуйд дэмжлэг үзүүлэхээр зээл олгосон

Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэлийн салбар

- 2015 онд Засгийн газраас экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор дахин боловсруулалт, сав баглаа боодлын үйлдвэрлэлд зээл олгосон

Дээрх арга хэмжээнүүдийн дийлэнх нь 2012-2015 онд ашигт малтмалын түүхий эдийн өндөр үнэ болон Хятадын эдийн засгийн өндөр өсөлтөөс шалтгаалсан үндэсний эдийн засаг өндөр өсөлттэй байсан үед хэрэгжсэн. Бондын хөрөнгө оруулалтаар улсын төсвийг нэмэгдүүлсэн бөгөөд 1.5 тэрбум ам.долларын Чингис бондын хөрөнгө оруулалтын зарим хэсгийг Хөгжлийн банкаар дамжуулан хөнгөлөлттэй зээл хэлбэрээр экспортын төслүүдэд зарцуулсан. Гэсэн хэдий ч тэдгээр төслийн хэрэгжилтийг хянаж үзээгүй байна.

Санхүүгийн бус бодлогын арга хэмжээнд “нэг цонхны үйлчилгээ”-г нэвтрүүлэх, “хөдөө аж ахуйн бирж”-ийг байгуулах үйл ажиллагаа хамаарах боловч эдгээрийн үр дүн хангалтгүй байна.

2007 оноос хойш “нэг цонхны үйлчилгээ”-г нэвтрүүлэх ажил эхэлж галийн мэдээллийг онлайнаар хүргэдэг гаалийн автомат мэдээллийн систем гэх мэт зүйлсийг нэвтрүүлсэн боловч “нэг цонхны үйлчилгээ”-г нэвтрүүлэх ажил бүрэн хэрэгжээгүй байна. Судалгаанаас харахад түвэгтэй, нүсэр, тодорхойгүй худалдааны үйл ажиллагаанаас болж Монголын худалдааны зардал өндөр байдаг. 2016 оны Дэлхийн Банкны Бизнес Эрхлэхүй (Doing Business) судалгааны тайланд Монгол Улс хил дамнан худалдаа хийхэд хялбар байдлаараа 189 орноос 102-р байрт жагссан бөгөөд үүнээс хойш энэ эрэмбэ улам муудаж 2017 онд 103, 2018 онд 108-д жагсжээ. Логистикийн гүйцэтгэлийн индексээр (Logistics Performance Index) 2014 онд 160 улсаас 135, 2016 онд 108-д жагсаж байна. Монголыг гаалийн бүрдүүлэлт хийх болон хилийн боомтоор нэвтрэх үзүүлэлтээр хамгийн бага оноогоор үнэлдэг. Хэт их үзлэг шалгалт хийх нь удаан хүлээх шалтгаан болдог бол тээвэрлэлтийн үеийн хадгалалт, хамгаалалтын зардлаас шалтгаалан худалдаачид их хэмжээний зардал гаргадаг (АХБ-ны Салбарын Үнэлгээ: Аж Үйлдвэр, Худалдаа 2016)

Газарзүйн байршил, муу дэд бүтэц, мэдээлэл, харилцаа холбооны технологийн ашиглалт бага, олон улсын худалдааны үр ашиггүй байдал нь бүхэлдээ худалдааны өндөр зардал, худалдааны бага хэмжээнд нөлөөлдөг. Засгийн газраас дэд бүтцийн асуудлыг шийдэх зорилготойгоор Транзит Монгол хөтөлбөр хэрэгжүүлэх болон хөрш зэргэлдээ орнуудын бүс нутгийн хамтын ажиллагаа явуулах гэх мэт үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа боловч бодит үр дүнд хүрэхээс өмнө цаг хугацаа их шаардана. Энэ хугацаанд бүс нутгийн худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг өргөжүүлэх, худалдааны түншүүдтэй чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах замаар нөхцөл байдлыг сайжруулах талаар зарим алхмууд хийгдсэн байна. Тухайлбал, 2013 онд Монгол Улс Ази-Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэж, 2016 оны 6-р сард хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Японы Чөлөөт худалдааны хэлэлцээрт 2015 оны 2-р сард гарын үсэг зурсан.

Экспортыг дэмжих өөр нэг арга бол олон төрлийн сургалт, одоо байгаа болон боломжит экспортлогчдын чадавхыг сайжруулах үйлчилгээ юм. Эдгээрт экспортын бизнес сургалт; гадаадын зах зээлийн тухай мэдээлэл (ерөнхий эсвэл тусгайлсан дүн шинжилгээнд үндэслэсэн); экспортын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх зөвлөгөө, зааварчилгаа; гадаадад болон дотоодод бүтээгдэхүүнээ сурталчлах, үзэсгэлэн гаргах, боломжит үйлчлүүлэгчидтэй уулзалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх; жижиг экспортлогчдын консорциумын зохицуулалт; пүүс компаниудад өөрсдийн бүтээгдэхүүний чанарыг сайжруулахад туслах хөтөлбөрүүд зэрэг үйлчилгээнүүд хамаардаг (Жордана 2010).

Эдгээр үйлчилгээний заримыг ТББ болон олон улсын тусламжийн агентлагууд Монголын экспортлогч болон ирээдүйд бүтээгдэхүүнээ экспортлох боломжтой үйлдвэрлэгчдэд үзүүлдэг. Жишээлбэл, Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь экспортлогчдод дараах үйлчилгээг үзүүлдэг. Үүнд:

- Гарал үүслийн гэрчилгээ
- Патент, барааны тэмдгийн бүртгэл
- Арбитрын шүүх
- Гадаад худалдааны бичиг баримтын талаарх мэдээлэл
- Гадаадад үзэсгэлэн яармаг зохион байгуулах
- Бизнесүүдтэй холбоо барихад туслах
- Гадаад худалдааны менежментийн сургалтын хөтөлбөрүүд
- ЖДҮ-ийн зөвлөх үйлчилгээ.

Сургалтын хөтөлбөрийг АХБ, Дэлхийн Банк, Германы хөгжлийн агентлаг, Швейцарын хөгжлийн агентлаг (ШХА) хамтран хэрэгжүүлж байна.

Ерөнхийдөө, Засгийн газраас төсвийн болон бусад санхүүжилтийн эх үүсвэрүүд хангалттай байсан 2011-2015 онд салбаруудад чиглэсэн тусгай санхүүгийн арга хэмжээнүүд авсан. Харин 2016 оноос эдийн засаг буурч эхэлсэнтэй холбоотойгоор эдгээр хөтөлбөр ихээхэн хумигдсан. Засгийн газар худалдааны дэглэмийг хөнгөвчлөх зарим арга хэмжээг авсан. Гэсэн хэдий ч өнөөг хүртэл мэдэгдэхүйц сайжрал ажиглагдахгүй байна. Сургалт, үндсэн үйлчилгээнүүдэд шаардлагатай зарим санхүүгийн бус хязгаарлагдмал дэмжлэгийг төрийн бус байгууллагууд олгодог. Эдгээр үйл ажиллагаануудын үр өгөөж хязгаарлагдмал байна.

3. ЭМПИРИК ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Энэ хэсэгт бид тус судалгаанд ашиглагдсан судалгааны арга зүйг тайлбарлана. Бидний гол зорилго бол уул уурхайн бус экспортыг гүнзгийрүүлэн судлахад оршиж байгаа бөгөөд бид энэ судалгаандаа хоёр төрлийн арга зүйг ашигласан. Нэгдүгээр аргачлал нь гадаад худалдааны чиг хандлагыг судалдаг энэ төрлийн судалгаануудад түгээмэл ашиглагддаг харьцангуй давуу талд суурилсан. Тус аргачлалыг бид салбарын шинжилгээнд ашигласан. Судалгаанд ашигласан хоёр дах аргачлал нь хамгийн түгээмэл ашиглагддаг гадаад худалдааны гол загвар болох "таталцлын загвар" (gravity model). Энэхүү загварын тухай тайлангийн дараагийн холбогдох хэсэгт дэлгэрэнгүй тайлбарлах болно.

Гадаад худалдаанд харьцангуй давуу тал томоохон үүрэг гүйцэтгэдэг. Учир нь Засгийн газар бодлогоо харьцангуй давуу тал сайтай салбарууд дээр төвлөрүүлэх ёстой болдог. Харьцангуй давуу тал бүхий бүтээгдэхүүнүүдийг тодруулахын тулд бид 1965 онд анх Бела Балассагийн санал болгосон "Экспортын илэрсэн харьцангуй давуу талын (ЭИХДТ)" -ын индексийг ашиглана. Тус индекс нь гадаад худалдаанд хэрэглэгддэг хамгийн чухал загвар болох Давид Рикардогийн харьцангуй давуу талын онол дээр суурилсан ба энэхүү аргачлалыг боловсруулснаас хойш түгээмэл ашиглагдсаар байгаа. Хэдийгээр стандарт загварыг импортоор, цэвэр экспортоор, ҮНБ, үйлдвэрлэл зэргийг оруулан өргөтгөсөн хэдий ч эдгээрийн үр дүнгүүд өөр өөр байгаа учраас бид стандарт загварыг ашиглах болно.

Баласса болон Ноланд (1989) ЭИХДТ -ийн индексийг Япон болон АНУ-ын 57 анхдагч болоод 167 боловсруулсан бүтээгдэхүүний тоон мэдээлэл дээр үндэслэн тооцсон. Энэхүү судалгаандаа тэд ЭИХДТ болон хоёр орны экспортын бүтээгдэхүүний бүтцийн өөрчлөлт нь хоорондоо хамааралтай болохыг харуулсан. Үүний үр дүнд тус хоёр орон харьцангуй давуу талаа сайжруулж өндөр технологитой бүтээгдэхүүний экспортын хэмжээгээ өсгөсөн болохыг тогтоосон. Өөрөөр хэлбэл, харьцангуй давуу тал нь гадаад худалдаанд нөлөөлж болох төдийгүй Засгийн газрын бодлогод ч нөлөөлж болохыг харуулжээ. Муэндлэр (2007) 1986-аас 2001 оны хооронд дах Бразилийн хөдөө аж ахуйн, уул уурхайн болон боловсруулах салбарын тоон мэдээллийг ашиглан харьцангуй давуу тал болон гадаад худалдааны холбогдох үзүүлэлтүүдийн хоорондын хамаарлыг судалсан. Тус судалгаанд Бела Балассагийн боловсруулсан стандарт загварын ашиглажээ. Мүэндлэрийн ашигласан шугаман регрессийн загварын дагуу Бразил улсын хувьд харьцангуй давуу тал нь тарифтай төдийлөн холбоогүй /статистикийн хувьд ач холбогдолгүй/ ба бусад гадаад худалдаатай холбоотой хувьсагчтай холбоотой болох нь тогтоогдсон. Ийнхүү ЭИХДТ индекс нь экспортыг дэмжих бодлогыг боловсруулахад хэрэгтэй арга хэрэгсэл болох нь харагдсан.

Бидний ашигласан шинжилгээний хоёр дах арга хэрэгсэл нь "таталцлын загвар" юм. Таталцлын энгийн загвар 1960-аад онд гарсан ба тус загвар нь төдийлөн эдийн засгийн онолын үндэслэл сайтай биш бөгөөд Ньютоны таталцлын загварт суурилсан байдаг. Энэхүү загварын дагуу гадаад худалдаа нь эзэн орны болон түнш орны эдийн засгийн

хэмжээ болон хоорондын зайнаас хамаардаг гэж үздэг учраас эдийн засгийн онолтой төдийлөн нийцтэй биш гэсэн шүүмжлэлд ихээхэн өртдөг. Өөрөөр хэлбэл, тариф, газар зүйн байрлалын онцлогууд, тээвэрлэлтийн төрлүүд, харьцангуй үнүүд, валютын ханш зэрэг бусад хүчин зүйлс гадаад худалдаанд нөлөөгүй гэж үздэг.

Судлаачид таталцлын загварт эдийн засгийн онолын үндэслэл оруулах замаар сайжруулалт, хөгжүүлэлт хийсэн. Ихэнх тохиолдолд энэ таталцлын загварыг “сайжруулсан таталцлын загвар” гэж нэрлэдэг ба үүнийг Андерсон ба Викүүп (2003) анх дэвшүүлсэн. Стандарт таталцлын загварын үнэлгээ “орхигдсон (omitted)” хувьсагчийн хазайлт (bias)-ын нөлөөнд автсан байдаг. Тэд сайжруулсан загвараараа хилийн нөлөөг судалсан ба аж үйлдвэржсэн орнуудтай хиллэдэг байх нь тус орнуудын гадаад худалдааг 20-иос 50 хувиар бууруулдаг болохыг тооцоолжээ. Цаашилбал, Рабалланд (2003) улс орнууд далайд гарцгүй байх нь гадаад худалдаанд сөрөг нөлөөтэй болохыг “сайжруулсан таталцлын загвар”-ыг панел дата ашиглан тогтоосон. Тухайлбал, далайд гарцгүй байх нь гадаад худалдааг 80 гаруй хувиар бууруулах боломжтой гэдгийг дамми хувьсагч ашиглан тогтоосон. Хил давах тоо өндөр байх нь тээврийн зардлыг өсгөх бөгөөд энэ нь гол төлөв газрын тээвэрлэлтийн зардал далайн тээврээс өндөр байхад нөлөөлдөг болохыг тогтоосон. Энхболд, Өлзий-Очир (2016) нар “сайжруулсан таталцлын загвар”-ыг ашиглан Монголын гадаад худалдааны чиг хандлагыг шинжилсэн ба тус загварыг ашиглан гадаад худалдааны зардлыг тооцсон. Харамсалтай нь сонгож авсан хувьсагчид нь Монголын гадаад худалдааны урсгалд тодорхой нөлөө үзүүлэхгүй байгаа нь тогтоогдсон. Түүнчлэн, тус судалгаа уул уурхайн ба уул уурхайн бус гэж ялгалгүй нийт экспортыг судалсан.


Шинжилгээний арга зүйгээс үл хамааран бид өөр эх сурвалжийн өөр өөр тоон мэдээлэл ашиглана. Бид ЭИХДТ индексийг салбар тус бүрээр тооцоолохдоо түүхэн тоон өгөгдөл болон мэдээллүүдийг ашигласан. Тоон өгөгдлийг бид Дэлхийн банк болон Олон улсын худалдааны төв (International trade center)-ийн Дэлхийн гадаад худалдааны нэгдсэн шийдэл (World integrated trade solutions) болон гадаад худалдааны газрын зураг (Trade map) зэрэг мэдээллийн сангаас авсан. Цаашилбал, Монгол Банк, Үндэсний статистикийн хороо, Гаалийн ерөнхий газар зэрэг албан ёсны байгууллагуудын тоон мэдээллийг ашигласан.

4. ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ БОДЛОГЫН САЛБАРУУДАД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Салбарын шинжилгээний гол зорилго нь тэргүүлэх чиглэлээр тодорхойлогдсон, гадаад худалдаанд томоохон үүрэг гүйцэтгэдэг, ирээдүйд экспортын голлох салбар болох боломжтой салбаруудад дэлгэрэнгүй шинжилгээ хийхэд оршино. Доорх зурагт уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүнүүдийн нийт уул уурхайн бус экспортод эзэлж буй хувийн жинг харуулж байна. Ноос ноолуур, нэхмэлийн салбарын бүтээгдэхүүний экспорт нь уул уурхайн бус экспортын талаас илүү хувийг эзэлдэг. Өөр нэг экспортын бүтээгдэхүүн болох машин тоног төхөөрөмж нь 2012 оноос хойш огцом өссөн.

Бид голлох салбаруудыг харьцангуй давуу тал, үйлдвэрлэлд эзлэх хөдөлмөрийн хувийн жин, төрийн болоод төрийн бус байгууллагын татаас, дэмжлэг зэргийг тооцоолох замаар сонгож авсан.

Зураг 7. Уул уурхайн бус экспорт, салбараар, сая ам.доллар



Эх сурвалж: ҮСХ, Гаалийн ерөнхий газар

Бид Балассагийн санал болгосон ЭИХДТ индексийг салбар тус бүрээр тооцоолсон. ЭИХДТ индексийг тооцоход дараах томъёоллыг ашигласан ба энэ нь тухайн бүтээгдэхүүний экспортын тухайн улсын экспортод эзлэх хувийн жинг тухайн бүтээгдэхүүний нийт дэлхийн экспортод эзэлж буй хувийн жинд харьцуулах замаар тооцдог.

$$\text{ЭИХДТ} = \frac{X_{ije}}{\sum_i X_{ij}} \div \frac{\sum_i X_{iw}}{\sum_i \sum_w X_{iw}}$$

Энд X экспорт, i, j, w нь бүтээгдэхүүн, орон, дэлхийг тус тус тэмдэглэж байгаа.

Энэхүү ЭИХДТ индекс нэгээс их бол j орон i бүтээгдэхүүний хувьд дэлхийтэй харьцуулахад харьцангуй давуу талтай гэсэн үг. (Balassa B., 1965).

Тухайн орны гадаад худалдааны харьцангуй давуу талын бүтцийг M матрицаар үзүүлэх боломжтой. M матрицыг дараах байдлаар тодорхойлно.

$$M = \begin{cases} 1 & \text{хэрэв ЭИХДТ} > 1 \\ 0 & \text{хэрэв ЭИХДТ} < 1 \end{cases}$$

Энд $M > 1$ бол j орон i бүтээгдэхүүний хувьд экспортын давуу талтай гэсэн үг.

Дараах хүснэгтэд харьцангуй давуу талыг харуулж байгаа бөгөөд Монгол улс 2017 он хүртэл ноос ноолуур, нэхмэл бүтээгдэхүүн болон арьс шир, арьс ширэн бүтээгдэхүүний салбарын хувьд харьцангуй давуу талтай байсан байна.

Хүснэгт 4. Экспортын илэрсэн харьцангуй давуу тал (ЭИХДТ), тэргүүлэх салбараар

	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Ноос, ноолуур, нэхмэл эдлэл	2.20	2.25	1.77	1.20	1.32	1.57	1.33	1.38	1.29	0.92
Арьс шир, арьс ширэн эдлэл	3.01	2.73	1.89	1.76	1.13	1.24	0.93	1.03	0.91	0.34
Үндсэн төмөрлөг	0.11	0.13	0.10	0.07	0.07	0.08	0.12	0.23	0.28	0.28
Машин тоног төхөөрөмж	0.04	0.04	0.02	0.01	0.02	0.05	0.05	0.04	0.08	0.01
Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	0.02	0.11	0.01	0.04	0.04	0.08	0.15	0.29	0.39	0.81
Мах, малын гаралтай бүтээгдэхүүн	0.75	1.24	1.33	0.46	0.31	0.30	0.14	0.29	0.29	0.55
Хүнсний бүтээгдэхүүн	0.05	0.09	0.07	0.06	0.07	0.11	0.06	0.10	0.07	0.06
Хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэл	0.02	0.01	0.01	0.01	0.01	0.02	0.01	0.01	0.03	0.02

Эх сурвалж: судлаачдын тооцоолол


Бид харьцангуй давуу тал бүхий хоёр бүтээгдэхүүн болох ноос ноолуур, нэхмэл бүтээгдэхүүн болон арьс шир, арьс ширэн бүтээгдэхүүнүүд, харьцангуй давуу талгүй боловч ЭИХДТ индекс нь байнга сайжирч байгаа ургамлын гаралтай бүтээгдэхүүнүүдийг сонгож авсан. Эдгээр гурван сектор дээр нэмээд судалгааны баг үндсэн метал, машин тоног төхөөрөмж, мах болон бусад малын гаралтай бүтээгдэхүүнүүдийг бусад шалгуур үзүүлэлт ашиглан сонгож авлаа. Эдгээрийг сонгосон шалтгаан нь нэгдүгээрт, сүүлийн жилүүдэд үндсэн метал болон машин тоног төхөөрөмжийн уул уурхайн бус экспортод эзлэх хувийн жин улам өсөх болсон. Хоёрдугаарт, малын гаралтай бүтээгдэхүүний салбар хөдөлмөрийг түлхүү ашигладаг бөгөөд ажил эрхлэлтэд томоохон үүрэг гүйцэтгэдэг. Мөн нүүдлийн мал аж ахуй болон соёл нь газар зүйн төрөл бүрийн тогтоц бүхий уужим тал нутагтай хосолсноор аялал жуулчлалын таатай нөхцөлийг бүрдүүлдэг гэж олон хүмүүс үздэг.

4.1. Ноос, ноолуур, нэхмэл бүтээгдэхүүний салбар

Сүүлийн 20 жилд ноос, ноолуур, нэхмэлийн салбарын бүтээгдэхүүний экспорт гурав дахин өссөн. Эдийн засгийн өсөлт харьцангуй өндөр байгаа үед ноос, ноолуур, нэхмэлийн салбар өсөж байгаа буюу эдийн засгийн өсөлт болон экспорт хоёрын хооронд эерэг хамаарал байгаа нь ажиглагдаж байна. Энэ төрлийн бүтээгдэхүүний экспорт 2014 оны байдлаар 339 сая ам.доллар байсан бол 2016 оны байдлаар 300 сая ам.доллар болон буурчээ. Энэ салбарын гол экспортын бүтээгдэхүүн болох “ноос, мал, амьтны нарийн


буюу бүдүүн үс, ноос, хялгас; адууны хялгасан ээрмэл, тэдгээрийн нэхмэл даавуу”² нь энэ төрлийн бүтээгдэхүүний нийт экспортын 90 орчим хувийг бүрдүүлж байна. Түүнчлэн, “сүлжмэл хувцас ба хувцасны сүлжмэл тоног хэрэгсэл” үлдсэн 10 хувийг эзэлдэг.

Зураг 8. Нэхмэлийн экспорт, сая ам.доллар



Эх сурвалж: YCX, Гаалийн ерөнхий газар

Зураг 9. Нэхмэлийн салбарын ЭИХДТ индекс



Эх сурвалж: Судалгааны багийн тооцоолол

Монголын Засгийн Газраас ноос, ноолуур, нэхмэлийн салбарын бүтээгдэхүүний экспортыг дэмжих чиглэлээр бодлого арга хэмжээ, хөтөлбөрүүд олныг хэрэгжүүлсэн байдаг. Засгийн газар 2011 оноос хойш үндэсний ноолуур болон ноос үйлдвэрлэгчдэд 273 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Энэхүү хөтөлбөр 2014 онд зогссон байна. Түүнчлэн, 2011 оноос хойш Засгийн газраас ноос болон ноолуурын гол ханган нийлүүлэгчид болох малчдад бэлэн мөнгөний урамшуулал олгосон ба үүнд нийтдээ 50 тэрбум төгрөг зарцуулсан юм. Эдгээр арга хэмжээний үр дүнд тус салбарын харьцангуй давуу тал 2011-ээс 2014 онуудад өссөн. Ялангуяа, 2013, 2014 онд огцом өсөлт ажиглагдаж экспорт 283 болон 339 сая ам.доллар болж тус тус өсжээ.

Экспортыг дэмжих, импортыг орлох дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Засгийн газар ноос, ноолуур, нэхмэл бүтээгдэхүүний салбарт 2013-аас 2015 онуудад ихээхэн хэмжээний хөнгөлөлттэй зээл олгосон ба нийт 5.3 тэрбум төгрөг зарцуулсан байна. Засгийн газар энэхүү хөнгөлөлттэй зээлийг Чингис бондоор санхүүжүүлсэн ба эдгээр зээлийн зарим хэсгийг Хөгжлийн банкаар дамжуулан олгосон. Хөнгөлөлттэй зээлүүд нь ноос, ноолуур, нэхмэл бүтээгдэхүүний экспортыг дэмжээд зогсохгүй тус салбарын харьцангуй давуу талыг нийтэд нь сайжруулсан гэж үзэж болохоор байна. Түүнчлэн, ноос, ноолуур, нэхмэл бүтээгдэхүүний экспортыг дэмжих зорилгоор Засгийн газар 2015 онд хэд хэдэн төрлийн ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортын НӨАТ-

² Голлох бүтээгдэхүүнүүд нь “бусад мал, амьтны сэмлээгүй буюу самнаагүй үс, хялгас” болон “мал амьтны самнасан үс, хялгас”.


ийг төлбөрийг тэглэсэн. Хэдийгээр ноос, ноолуур, нэхмэл бүтээгдэхүүний экспорт 2015 онд буурсан ч тус салбарын харьцангуй давуу тал 1.3-аас 1.4 болж өсжээ. Харин 2017 онд ЭИХДТ индекс огцом буурсан ба энэ нь уул уурхайн салбарын экспорт өссөнтэй холбоотой.

4.2. Арьс шир, арьс ширэн бүтээгдэхүүний салбар

Арьс шир, арьс ширэн бүтээгдэхүүний экспортод нөлөөлөгч гол хүчин зүйл нь зуд болон ган гачиг юм. Зуд болон ган гачиг тохиолдож ихээхэн тооны малын хорогдол гарсны дараа энэ салбарын экспорт огцом өсдөг болох нь ажиглагдсан. Жишээ нь 2010 онд тохиосон зуд болон гангаас улбаатай малын хорогдол огцом өссөн бөгөөд 2011 онд савхин бүтээгдэхүүний экспорт 51 сая ам.доллар болж огцом өссөн байна.


Энэ салбарын экспортын 99 хувийг “арьс, ширэн түүхий эд (ангийн үснээс бусад) ба боловсруулсан арьс, шир” эзэлдэг. Эдгээр бүтээгдэхүүний экспорт 2016 онд 26 хувиар буурснаар эдгээр бүтээгдэхүүнүүдийн тус салбарт эзлэх хувийн жин буурсан бол “боловсруулсан арьс ширэн эдлэл; суран эдлэл ба тоног хэрэгсэл; аяны хэрэгсэл; эмэгтэй хүний цүнх”-ийн эзлэх хувийн жин 3 хувиас 20 хувь болон өссөн.

Зураг 10. Арьс шир, арьс ширэн бүтээгдэхүүний экспорт, сая ам.доллар



Эх сурвалж: YCX, Гаалийн ерөнхий газар

Зураг 11. Арьс шир, арьс ширэн бүтээгдэхүүний ЭИХДТ индекс



Эх сурвалж: Судалгааны багийн тооцоолол

Арьс шир, арьс ширэн бүтээгдэхүүн бол манай улсын харьцангуй давуу тал бүхий уул уурхайн бус хоёр бүтээгдэхүүний нэг нь юм. Монголын Засгийн газар 2012 оноос хойш эдгээр бүтээгдэхүүнийг дэмжих бодлого баримталж ирсэн. Энэ хүрээнд Засгийн газар арьс ширийг гүн боловсруулах үндэсний үйлдвэрлэгчдэд 2012-2014 онд 64.37 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Хэдийгээр энэхүү бодлого нь арьс шир, арьс ширэн бүтээгдэхүүний экспортыг өсгөсөн хэдий ч зээлийн хэмжээ нь тус салбарын харьцангуй давуу талыг өсгөхүйц байж чадаагүй. Жишээ нь тус бүтээгдэхүүний экспорт 2012 онд 31 сая ам.доллар байсан бол 2014 онд 36 сая ам.доллар болжээ.

Гэсэн хэдий ч энэхүү зээлийн экспортод үзүүлж буй нөлөө зуд болон ган гачигтай харьцуулахад бага байгаа нь харагдаж байна. Цаашилбал, 2012 оноос хойш Засгийн

газар үндэсний арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд түүхий эд нийлүүлж буй малчдад бэлэн мөнгөний урамшуулал олгох болсон. Энэ хүрээнд 2013-2015 онд Засгийн газар 20.2 тэрбум төгрөг зарцуулсан байна. Түүнчлэн, 2015 онд Засгийн газар хэд хэдэн төрлийн арьс шир, арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн НӨАТ-ыг тэглэсэн. Гэсэн хэдий ч энэ арга хэмжээ нь тус салбарын экспортод тодорхой нөлөө үзүүлээгүй.


Засгийн газар хэд хэдэн төрлийн бодлого, хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн хэдий ч тус салбарын харьцангуй давуу тал 2008 оноос хойш тогтвортойгоор буурсаар ирсэн. Жишээлбэл, 2008 онд ЭИХДТ индекс 3.0 байсан бол түүнээс хойш 2 орчим нэгжээр буурч 2016 онд 0.9 болсон байна. Тухайлбал, энэ салбарын харьцангуй давуу тал 2008-2012 онд огцом буурчээ. Хэдийгээр Засгийн газраас авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээнүүд харьцангуй давуу талыг тогтворжуулсан боловч сүүлийн хоёр жилд энэ салбарын харьцангуй давуу тал буурсан байна.

4.3. Экспортын бусад салбар


Энэ хэсэгт бид үндсэн металл, машин, тоног төхөөрөмж, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, мах болон бусад малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг авч үзнэ. Эдгээр төрлийн бүтээгдэхүүний экспорт сүүлийн арван жилд өссөөр ирсэн. Жишээлбэл, үндсэн металл, машин, тоног төхөөрөмжийн экспорт дөрөв дахин өсжээ. Бидний тооцооллоор энэ салбарын ЭИХДТ индекс 1-ээс бага байгаа нь харьцангуй давуу тал байхгүй болохыг харуулсан. (Хүснэгт 1)

Үндсэн металлын экспорт сүүлийн жилүүдэд ерөнхийдөө өсөлттэй байгаа ба 2016 оны байдлаар 86 сая ам. долларт хүрчээ. Энэ бүтээгдэхүүний 90 гаруй хувийг “зэс болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн” эзэлж байна. Зэс болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн гэдэгт зэс хавтан, тунгаасан зэс ба хайлшны бүтээгдэхүүн ордог. Тус бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2014 онд “Ачит ихт” ХХК катодын зэс үйлдвэрлэж, экспортолж эхэлсэнтэй холбоотойгоор огцом өссөн.

Зураг 12. Суурь металлын экспорт, сая ам.доллар



Зураг 13. Машин, тоног төхөөрөмжийн экспорт, сая ам.доллар




Эх сурвалж: YCX ба Гаалийн ерөнхий газар


Машин, тоног төхөөрөмжийн экспорт 2016 он гэхэд 2008 оноос 5 дахин өсжээ. Ялангуяа 2013 оноос хойш эрчимтэй өсөж 2016 он гэхэд 141 сая ам. долларт хүрсэн. Энэ төрлийн экспортын бүтээгдэхүүнүүдийн 85-90 хувийг “цөмийн реактор, уурын тогоо, машин ба механик төхөөрөмж, тэдгээрийн эд анги”³ болон “Төмөр зам буюу трамвайн замын хөдлөх бүрэлдэхүүнээс бусад тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги” төрлийн бүтээгдэхүүнүүд эзэлдэг. Гэвч 2017 онд энэ бүтээгдэхүүний экспорт огцом уналтад орсноос харахад энэ нь уул уурхайн болон дэд бүтцийн салбарт огцом өсөлт гарч байх үед орж ирсэн тоног төхөөрөмж экспортлогдон гадагшаа гарсан байх талтай.

Ургамлын гаралтай бүтээгдэхүүний экспорт 2013 оноос хойш огцом өсөж 2017 он гэхэд 68 сая ам.долларт хүрсэн. “Жимс, жимсгэнийн ургамал, самар; жүржийн буюу гуаны төрлийн жимсний хальс”⁴болон “тослог үр ба жимс; бусад үр, жимс; үйлдвэрлэлийн болон эмнэлгийн зориулалттай ургамал”⁵ зэрэг бүтээгдэхүүнүүд энэ төрлийн экспортын 90 орчим хувийг эзэлдэг.

Зураг 14. Ургамлын төрлийн бүтээгдэхүүний экспорт, сая ам.доллар



Зураг 15. Мах, малын гаралтай бүтээгдэхүүний экспорт, сая, ам.доллар



Эх сурвалж: ҮСХ ба Гаалийн ерөнхий газар

Мах болон малын гаралтай бусад бүтээгдэхүүний экспорт 2010 онд 69 сая ам.доллар байсан бол 2014 он гэхэд энэ экспорт буурч 17 сая ам.долларт хүрсэн. Харин 2017 он гэхэд буцаад өсөж 67 сая ам. долларт хүрсэн. Энэ төрлийн экспортын гол бүтээгдэхүүнүүд нь “мах, хүнсний дайвар бүтээгдэхүүн”⁶болон “бусад газар заагдаагүй,

³ Голлох бүтээгдэхүүнүүд нь ‘гадаад худалдааны ангиллын 8425-8430 дугаартай бүтээгдэхүүнүүд’ болон ‘өргөгч, ачигч, буулгагч зэрэг машин механизмд зориулалттай эд анги’.

⁴ Гол бүтээгдэхүүнүүд нь “бусад самар” буюу хушны самар.

⁵ Гол бүтээгдэхүүнүүд нь ‘хээрийн байцаа’.

⁶ Голлох бүтээгдэхүүн нь адууны мах, өлөн гэдэс давсаг гүзээ.

мал амьтны гаралтай бүтээгдэхүүн” байдаг. 2010 онд “мах, хүнсний дайвар бүтээгдэхүүн” нь мах болон малын гаралтай бусад бүтээгдэхүүний экспортын 78.5 хувийг эзэлж байсан ба 2017 он гэхэд энэ нь 81.4 хувь болон өссөн.

5. ТӨЛӨВЛӨЖ БАЙГАА ЗАСГИЙН ГАЗРЫН БОДЛОГЫН ҮР НӨЛӨӨ

2016 оны 6 дугаар сарын сонгуулийн дараа, шинээр байгуулагдсан Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөрөө боловсруулсан. “Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2016-2020” нь эдийн засгийн хүндрэлийг даван туулах, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах нарийвчилсан арга хэмжээнүүдээс бүрдэнэ. Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан экспортыг дэмжих бодлоготой холбоотой ихэнх арга хэмжээ нь экспортыг тусгайлан дэмжих арга хэмжээнээс илүүтэйгээр үйлдвэржилтийг дэмжих ерөнхий арга хэмжээний нэг хэсэг болгон орсон байсан. Тэдгээр үйлдвэржилтийг дэмжих ерөнхий арга хэмжээ нь Монголын бүтээгдэхүүнүүдийн өрсөлдөх чадварыг сайжруулах замаар экспортыг нэмэгдүүлнэ.

Тодруулбал, манай судалгааны баг экспортын дэмжих бодлоготой холбоотой 18 арга хэмжээг сонгосон боловч талаас бага хувь нь экспортыг тусгайлан дэмжихэд чиглэгдсэн байна. Эдгээрээс ихэнх арга хэмжээ нь экспорттой холбоотой зардлыг багасгахад чиглэгдсэн бөгөөд худалдааны саад тотгорыг багасгаж, гаалийн болон хилийн шалгалтын шаардлагуудыг хөнгөвчлөх зорилготой байна. Зарим арга хэмжээ нь экспортыг дэмжихээс илүүтэй импортыг орлуулахтай холбоотой байлаа.

Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээнүүдэд төсвийг төлөвлөж, хэрхэн хэрэгжүүлэх аргыг тусгасан байдаг хэдий ч экспортыг дэмжих арга хэмжээнүүдийн ихэнх нь тодорхой санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлоогүй байна. Санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлсон цөөн хэдэн арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Уул уурхайн бус экспортыг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх үндсэн байгууллагууд нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Сангийн яам юм. Сангийн яам нь татварын хөнгөлөлтийг хэрэгжүүлж, экспортлогчдод хөнгөлөлттэй зээл олгох үүрэгтэй бөгөөд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь экспортыг дэмжих бодлогын арга хэмжээний олонхыг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг.

Засгийн газар болон холбогдох бусад төрийн байгууллагууд нь экспортыг дэмжих бодлогын нэг хэсэг болгож Монгол Экспорт 2018 хөтөлбөрийг боловсруулан, олон нийтэд санал болгож хэлэлцүүлсэн.

5.1 “Монгол Экспорт 2018” хөтөлбөрийн зорилго, зорилт

Монгол Экспорт хөтөлбөрийн зорилго нь “Монгол Улсын экспортын хууль эрх зүй, хөрөнгө оруулалт, санхүү, татварын тогтвортой таатай орчныг бий болгох, зах зээлийн мэдээлэл, судалгааны хүртээмжийг нэмэгдүүлэх, олон улсад сурталчлах, инноваци, тэргүүний дэвшилтэт техник, технологид суурилсан боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, экспортын бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулах, экспортын үйлдвэрлэлийг дэмжих, дэд бүтцийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх,

худалдааг хөнгөвчлөх, шинээр ажлын байр бий болгох, Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх, экспортоос эдийн засагт орох мөнгөн урсгалыг нэмэгдүүлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэхэд оршино”.

Энэхүү хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах дөрвөн зорилтыг дэвшүүлсэн. Зорилтыг дараах байдлаар өөрчлөхийг санал болгож байна:

Хүснэгт 5. “Монгол Экспорт 2018” хөтөлбөрийн зорилтуудад санал болгож байгаа өөрчлөлтүүд

Одоогийн хувилбар	Санал болгож буй өөрчлөлт
1. Экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын хууль эрх зүй, санхүү, татварын таатай орчныг боловсронгуй болгох;	1. Экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын хууль эрх зүй, санхүү, татварын таатай орчныг боловсронгуй болгох;
2. Уул уурхайн бус бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлэх, тэргүүний дэвшилтэд техник технологийг нэвтрүүлэх;	2. Худалдааг хөнгөвчлөх нэгдсэн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх;
3. Уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг төрөлжүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;	3. Экспортыг дэмжих төрийн үйлчилгээг сайжруулах
4. Худалдааг хөнгөвчлөх, экспортын зах зээлийн хүрээг тэлэх, шинэ зах зээлд нэвтрэх зэрэг болно.	4. Бусад оролцогчдын экспортыг дэмжих үйл ажиллагааг зохицуулах, экспортлогч нарт зориулсан төрийн бус үйлчилгээг нэмэгдүүлэх

Эх сурвалж: Монгол Экспорт Хөтөлбөр, судлаачдын санал

Зарим зорилтууд ялангуяа зорилт 2 ба 3-ыг хөтөлбөрийн ерөнхий зорилгод оруулах боломжтой. Зорилт бүрийг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газар болон бусад талуудын авах арга хэмжээний жагсаалтыг хөтөлбөрт тусгажээ. Дээрх зорилт бүрийн хүрээнд авах арга хэмжээний бүрэн жагсаалтыг Хавсралт 5-аас харна уу.

Бидний үзэж буйгаар нэр бүхий 4 зорилтод хүрэх арга хэмжээнүүд нь яг тухайлсан зорилтод чиглэсэн гэхээсээ илүүтэйгээр олон зорилтод чиглэж байна. Тиймээс санал болгож байгаа арга хэмжээнүүдийг дараах байдлаар бүлэглэх саналтай байна.

Хүснэгт 6. “Монгол Экспорт 2018” хөтөлбөрийн дагуу авах арга хэмжээ (шинээр зохион байгуулагдсан)

Хөтөлбөрийн хүрээнд авах арга хэмжээ (хариуцсан байгууллага)	
I. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД - Улсын их хурал, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам	
3.1.2. Экспортыг дэмжихтэй холбогдсон зохицуулалт, заалтуудыг одоо мөрдөж буй “Өрсөлдөөний тухай хууль”, “Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль”, “Хөрөнгө оруулалтын тухай хууль”, “Хөдөө аж ахуйн биржийн тухай хууль” болон бусад холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулах,	
3.1.5. Ноос, ноолуурын анхан шатны боловсруулалтыг төр, хувийн хэвшлийн хяналттай болгох зорилгоор аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах,	
3.1.6 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд үйлдвэрлэлийн боловсруулалтын түвшнийг ахиулах, үйлдвэрүүдийн дотооддоо хоршин ажиллах үйл ажиллагааг дэмжсэн зохицуулалтыг тусгасан нэмэлт өөрчлөлт оруулах,	
3.4.10. Экспортын бүтээгдэхүүний цахим худалдааг нэвтрүүлэх чиглэлээр судалгаа хийх, эрх зүйн орчин бүрдүүлэх,	
II. САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ - Сангийн яам, Татварын ерөнхий газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	
3.1.7. Үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнээ экспортолдог нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрүүдийн импортын түүхий эд, туслах материал болон тоног төхөөрөмж худалдан авахад татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг үе шаттайгаар эдлүүлэх	
3.1.8. Дундаас дээш технологийн агууламж бүхий бүтээгдэхүүн экспортолсон үйлдвэрлэл эрхлэгчдэд татварын хөнгөлөлт эдлүүлэх,	
3.1.9. Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг салбарын хөгжлийн бодлоготой уялдуулан, экспортын үйлдвэрт олгох эх үүсвэрийг бүрдүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох,	
3.1.12. Аймгуудад хорио цээрийн тусгаарлагдсан бүс байгуулах, тухайн бүсэд байгуулагдах махны үйлдвэрүүд болон махны лабораториудыг гадаадын шууд хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээлд хамруулах асуудлыг дэмжих,	
III. ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ БОДЛОГО - Гадаад харилцааны яам, Элчин Сайдын яамд, дипломат төлөөлөгчийн газрууд	
3.1.1. Гадаад худалдаа, ялангуяа экспортод оролцож байгаа салбарууд, төрийн яамд болон агентлагуудын үйл ажиллагааг уялдуулах, үйлдвэрлэл-худалдаа-хөрөнгө	

оруулалтын цогц бодлогыг дэмжихэд чиглэсэн “Монгол Улсын төрөөс гадаад худалдааны салбарт баримтлах бодлого” -ыг боловсруулж батлуулах,

3.1.15. Дэлхийн худалдааны байгууллагын “Худалдаан дахь саад тотгорын тухай хэлэлцээр”-ийн хүрээнд гадаад худалдааны тарифын бус хориг саадыг багасгахад чиглэсэн боломжийг бүрэн дүүрэн ашиглах

3.1.17. “Хуурай боомт”-ын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд экспортын бүтээгдэхүүний дэлхийн зах зээлд гаргах тээвэрлэлтийг холимог тээврийн логикийн төв байгуулах,

3.4.1. ДХБ-ын “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”-ийн хүрээнд хөнгөлөлт эдлэх боломжоо бүрэн ашиглах, уг хэлэлцээрийг сурталчлан таниулах, сургалтыг зохион байгуулах,

3.4.3. Монгол-ОХУ-БНХАУ-ын эдийн засгийн коридорын хөтөлбөрийн хүрээнд худалдааг хөнгөвчлөх, хил гааль, хорио цээрийн үзлэг хяналтыг хялбаршуулах чиглэлээр тусгагдсан арга хэмжээ, транзит тээврийг хөнгөвчлөх зохицуулалтыг хэрэгжүүлэх,

3.4.4. Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, Япон Улсад экспортлох бараа бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, импортын бараануудад тавигддаг японы шаардлага стандартыг судлах, энэ чиглэлээр Японы ЖАЙКА байгууллагатай хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх,

3.4.8. Олон улсын гэрээнд нэгдэн орох замаар экспортын бүтээгдэхүүнд хийсэн тохирлын үнэлгээний үр дүнг худалдааны түнш орнуудад хүлээн зөвшөөрүүлэх, худалдааг хөнгөвчлөх арга хэмжээг хэрэгжүүлэх,

3.4.11. Монгол Улсаас гадаад орнуудад суугаа ЭСЯ, дипломат төлөөлөгчийн газруудаар экспортын бараа бүтээгдэхүүнийг сурталчлах үйл ажиллагааг эрчимжүүлэх,

3.4.12. Монгол Улсад ажиллаж буй олон улсын хөгжлийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, тэдгээрийн хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдэд экспортын хөтөлбөрийн төсөл, арга хэмжээнүүдийг тусгах, хамтран хэрэгжилтийг хангах,

IV. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ - Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

3.1.10. Гадаад худалдаанд шаардлагатай хууль эрх зүй баримт бичгүүд, гадаад зах зээлийн талаарх мэдээллийн нэгдсэн цахим хуудсыг нээн ажиллуулах,

3.1.11. Экспортын хууль эрх зүйн орчин, экспортын худалдаа эрхлэгчдийг “Монгол экспорт” гарын авлага, мэдээллээр хангах,

3.1.13. Хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, давхардлыг арилгах, шуурхай болгох санал боловсруулж шийдвэрлэх,

3.2.5. Гадаад худалдааны нэг цэгийн үйлчилгээг бий болгон ажиллуулах,

3.2.6. Мал, амьтны халдварт өвчний гаралт, тархалтыг бууруулах, мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, хяналт шалгалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох,

3.2.7. Экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүний сорилтын лабораторийн чадавхыг нэмэгдүүлэх,

3.3.4. Монголд ажиллаж байгаа ноолуур, ноосон болон хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийн чадавхыг олон улсын хэмжээнд хүргэхэд туслалцаа үзүүлэх, энэ чиглэлийн шинэ лабораторийг барьж байгуулах, тохирлын гэрчилгээ олгох үйл ажиллагааг бүх түвшинд дэмжих,

3.4.6. ЕХ-ны орнуудад гадаад худалдааны цахим нэг цонхны үйлчилгээг хэрэгжүүлж буй туршлагыг судлах, нэвтрүүлэх,

V. ТӨРИЙН БУС ҮЙЛЧИЛГЭЭ - ТББ, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд

3.1.4. Үйлдвэрлэл, экспортыг дэмжих хөгжлийн санхүүжилтийн шинэ бүтээгдэхүүн, арга хэрэгсэл бий болгох,

3.1.14. Экспортлогчдыг гадаад худалдааны эрсдэлээс хамгаалах зорилгоор экспортын зээлийн баталгаа, даатгалын тогтолцоог бий болгох,

3.1.16. Олон улсын хэмжилзүйн болон итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллагуудаас зохион байгуулдаг ур чадварын сорилтын хөтөлбөрт мах, махан бүтээгдэхүүн, чацаргана, зөгийн бал, ноос ноолуур, арьс шир зэрэг бүтээгдэхүүний сорилтын лабораториудыг хамруулах,

3.1.18 Экспортын бүтээгдэхүүнд шагнал олгох, экспортлогчдын тусгайлсан өдрийг бий болгох,

3.2.3. Олон улсын үзэсгэлэн, экспо, бизнес форумыг ОХУ, БНХАУ, Европын Холбоо, Япон, Өмнөд Солонгос, АНУ зэрэг орнуудад зохион байгуулах, үйлдвэрлэгч, экспортлогч компаниудыг үр ашигтай оролцоход дэмжлэг үзүүлэх,

3.2.4. Экспортын бүтээгдэхүүний түүхий эдийг бэлтгэж экспортын үйлдвэрүүдийг хангах чиглэлээр хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох,

3.2.8. Экспортод гаргах бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өртгийг бууруулах, өрсөлдөх чадварыг сайжруулах, инноваци, өндөр технологид суурилсан оюуны багтаамж өндөртэй экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг санхүүжүүлэх,

3.3.3. Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд зориулсан сургалт, семинар зохион байгуулах төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх,

3.3.6. Үндэсний бренд, газар зүйн заалттай бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, дэлхий нийтэд сурталчлах,

3.4.5. ЕХ, АНУ, Канад болон ОХУ-ын зах зээлд нэвтрэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, зах зээл, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээний судалгааг хийх,

3.4.7. ХАА-н бүтээгдэхүүний Монгол-Орос-Хятадын стандартуудыг ижилсгэх асуудлыг судлах, эдгээр орнуудын стандартын байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх,

3.4.2. Монгол Улсын экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Евразийн эдийн засгийн холбоотой Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломж, давуу болон сул тал, үр өгөөжийн талаар судалгаа хийх, туршлага судлах,

3.3.1. Олон улсын зах зээлд гарах боломжит экспортын шинэ салбар, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх судалгаанууд хийх,

3.4.9. Монгол Улс болон монголын хөрөнгө оруулалт, бизнесийн орчин, бараа бүтээгдэхүүнийг Европын олон нийт, бизнесийн салбарынханд сурталчлах зорилго бүхий жишиг сурталчилгааны төвийг Берлин хотноо байгуулах санал боловсруулах,

VI. ХУВИЙН СЕКТОРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА - Хувийн хэвшлийн байгууллагууд, экспортлогчид

3.1.3. “Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хөнгөн болон хүнсний салбарын экспортын үйлдвэрүүдийг байгуулах, санхүү, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх,

3.2.1 Мах, махан бүтээгдэхүүн, чацаргана, зөгийн бал, ноос ноолуур, арьс шир, оёмол зэрэг бүтээгдэхүүний стандартыг европын болон олон улсын стандартад нийцүүлэхэд дэмжлэг үзүүлэх,

3.2.2. Ноос, ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүний үйлдвэрүүдийн технологич, дизайнерын мэргэжлийн оюутнууд болон мэргэжилтнүүдийг Итали, Япон болон бусад тэргүүлэх орнуудад сургах ажлыг эрчимжүүлэх,

3.3.2. Экспортын нэмүү өртөг шингэсэн шинэ, брэнд бүтээгдэхүүн бий болгох арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх,

3.3.5. Гадаадын зах зээлд экспортлох боломжтой программ болон техник хангамжийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх,

Эх сурвалж: Монгол Экспорт 2018 Хөтөлбөр

Дээрх хүснэгтэд хувийн хэвшлийн хүрээнд тодорхойлсон үйл ажиллагааг хасахыг санал болгож байна.

5.2 Үндсэн шалгуур үзүүлэлтүүд

Хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах зорилгоор дараах үндсэн үзүүлэлтийг санал болгосон байна (2017 оны суурь үзүүлэлтүүдийг эхний баганад *-оор тэмдэглэв). Бид хүснэгтэд өөрчлөлт оруулахыг санал болгож байна (саналыг дараагийн баганад **-оор тэмдэглэв).

Хүснэгт 7. Монгол Экспорт 2018 Хөтөлбөрийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд

No	Шалгуур үзүүлэлт	Нэгж	Суурь түвшин, он *	Суурь түвшин, он **	Зорилтот түвшин, он	Мэдээллийн эх сурвалж
			2017	2017	2021	
1	Нийт экспортод ХАА-н гаралтай боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин	Хувь	9.0	8.1	15.0	Гаалийн ерөнхий газар
2	Экспортын сагс дахь уул уурхайн бус бүтээгдэхүүний тоо	Тоо	150	495/78	225	Гаалийн ерөнхий газар
3	Хөнгөн, хүнс, хөдөө аж ахуйн салбарын экспортын орлого	Ам.доллар (сая)	6,212.4	610.5	9,000.0	Гаалийн ерөнхий газар
4	Дэлхийн банкны “Бизнес эрхлэхүй” тайлангийн экспортын бүрдүүлэлт хийх хугацаа	Цаг	168	168	140	Дэлхийн банкны “Бизнес эрхлэхүй” тайлан
5	Дэлхийн банкны “Бизнес эрхлэхүй” тайлангийн экспортын бүрдүүлэлт хийх зардал	Ам.доллар (сая)	191	191		Дэлхийн банкны “Бизнес эрхлэхүй” тайлан

6	Худалдааны түнш орнуудтай тарифын болон тарифын хориг саадыг бууруулах хэлэлцээр байгуулах	Тоо	1	?	2	Гадаад харилцааны яам
---	--	-----	---	---	---	-----------------------

Эх сурвалж: Монгол Экспорт 2018 Хөтөлбөрийн төсөл
Жич: Суурь түвшин, он *- Хөтөлбөрт санал болгож буй
Суурь түвшин, он **- Судлаач нарын санал

7-р хүснэгтийн хоёр дахь баганад (Суурь түвшин, он **) буй үзүүлэлтүүдийн тайлбарыг дор өгөв.

1. Нийт экспортод ХАА-н гаралтай боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин

ХАА-н гаралтай боловсруулах үйлдвэрлэлд дараах бүлэг бүтээгдэхүүнүүдийг хамруулсан:

- Мал, амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн (Бүтээгдэхүүний ангиллын 2 оронгийн дагуу 02-05 дугаартай бүтээгдэхүүнүүд)
- Ургамлын гаралтай бүтээгдэхүүн (Бүтээгдэхүүний ангиллын 2 оронгийн дагуу 06-11 дугаартай бүтээгдэхүүнүүд)
- Мал, амьтан, ургамлын гаралтай өөх тос (Бүтээгдэхүүний ангиллын 2 оронгийн дагуу 15 дугаартай бүтээгдэхүүн)
- Хүнсний бэлэн бүтээгдэхүүн (Бүтээгдэхүүний ангиллын 2 оронгийн дагуу 16, 19, 23, 24 дугаартай бүтээгдэхүүнүүд)
- Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл (Бүтээгдэхүүний ангиллын 2 оронгийн дагуу 41-43 дугаартай бүтээгдэхүүнүүд)
- Мод, модон эдлэл (Бүтээгдэхүүний ангиллын 2 оронгийн дагуу 44 дугаартай бүтээгдэхүүнүүд)
- Нэхмэлийн материал болон нэхмэл бүтээгдэхүүн (Бүтээгдэхүүний ангиллын 2 оронгийн дагуу 51, 56, 57, 61, 63 дугаартай бүтээгдэхүүнүүд)
- Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйлс (Бүтээгдэхүүний ангиллын 2 оронгийн дагуу 64 дугаартай бүтээгдэхүүнүүд)

Эдгээр бүтээгдэхүүнүүдийн нийт экспортын дүн 503,4 сая ам.доллартай тэнцэж байгаа бөгөөд 2017 оны нийт экспортын дүнд эзлэх хувь нь 8.1 байна.

ХАА гаралтай боловсруулах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг ангилахад дараах хүндрэлтэй зүйлүүд тулгарч байлаа.

- 2 болон 4 оронгоор бүлэглэсэн бүтээгдэхүүн дунд ХАА гаралтай болон бусад гаралтай бүтээгдэхүүнүүд холилдсон байсан тул ялгаж ангилахад бэрхшээлтэй. Зарим бүтээгдэхүүний хувьд үйлдвэрлэлийн орцод маш бага ХАА гаралтай бүтээгдэхүүн ашиглагдаж байгаа, эсвэл импортын ХАА гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн орцод ашиглагдаж байдаг гэх мэт маш олон эргэлзээтэй зүйлс байна.

- ХАА гаралтай бүтээгдэхүүнийг ялгасны дараа боловсруулсан бүтээгдэхүүнийг ялгахад боловсруулалтын түвшнээр ялгаатай бүтээгдэхүүнүүд байгаагаас аль түвшний боловсруулалтыг боловсруулсан бүтээгдэхүүн гэж үзэх вэ гэдэг асуудал дагуулж байна.

2. Экспортын сагс дахь уул уурхайн бус бүтээгдэхүүний тоо

25-27, 71 гэсэн 2 оронгийн кодтой уул уурхайн бүтээгдэхүүнийг нийт экспортоос хасаж уул уурхайн бус бүтээгдэхүүнийг ялгаж авсан. Энэ үзүүлэлтийг тооцоходоо 2017 оны экспорт нь 0-ээс их байгаа уул уурхайн бус бүтээгдэхүүнийг оруулсан болно. Эдийн засгийн ангиллын 2 орны түвшинд тооцоход нийт 78 бүтээгдэхүүн, 4 орны түвшинд нийт 495 бүтээгдэхүүн байсан.

3. Хөнгөн, хүнс, хөдөө аж ахуйн салбарын экспортын орлого

Хөнгөн, хүнс, хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүнд дараах бүтээгдэхүүнүүдийг хамруулав. Эдгээр бүтээгдэхүүнүүдээс хөнгөн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг сонгохдоо Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн яамны хөнгөн үйлдвэрлэлийн салбарт харьяалагдаж байгаа бүтээгдэхүүнүүдийг авсан болно.

- Мал, амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн (Бүтээгдэхүүний ангиллын 2 оронгийн дагуу 01-05 дугаартай бүтээгдэхүүнүүд)
- Ургамлын гаралтай бүтээгдэхүүн (Бүтээгдэхүүний ангиллын 2 оронгийн дагуу 06-14 дугаартай бүтээгдэхүүнүүд)
- Мал, амьтан, ургамлын гаралтай өөх тос (Бүтээгдэхүүний ангиллын 2 оронгийн дагуу 15 дугаартай бүтээгдэхүүн)
- Хүнсний бэлэн бүтээгдэхүүн (Бүтээгдэхүүний ангиллын 2 оронгийн дагуу 16-24 дугаартай бүтээгдэхүүнүүд)
- Хуванцар, каучук болон түүгээр хийсэн зүйлс, хаймар болон түүгээр хийсэн зүйлс (Бүтээгдэхүүний ангиллын 2 оронгийн дагуу 39-40 дугаартай бүтээгдэхүүнүүд)
- Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл (Бүтээгдэхүүний ангиллын 2 оронгийн дагуу 41-43 дугаартай бүтээгдэхүүнүүд)
- Мод, модон эдлэл (Бүтээгдэхүүний ангиллын 2 оронгийн дагуу 44-46 дугаартай бүтээгдэхүүнүүд)
- Нэхмэлийн материал болон нэхмэл бүтээгдэхүүн (Бүтээгдэхүүний ангиллын 2 оронгийн дагуу 50-63 дугаартай бүтээгдэхүүнүүд, энд оёдлын салбар бүхэлдээ багтана)
- Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйлс (Бүтээгдэхүүний ангиллын 2 оронгийн дагуу 64-67 дугаартай бүтээгдэхүүнүүд)
- Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа (Бүтээгдэхүүний ангиллын 2 оронгийн дагуу 94-96 дугаартай бүтээгдэхүүнүүд)

Энэ төрлийн бүтээгдэхүүнд бүх төрлийн уул уурхайн үйл ажиллагаа, төмөрлөгийн үйл ажиллагаа, машин механизм тоног төхөөрөмж, химийн үйлдвэрлэл, бүх төрлийн

чулуулгаар хийсэн үйлдвэрлэл (цемент, шохой, шил, шилэн бүтээгдэхүүн гэх мэт), хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналтын багаж хэрэгслүүд (эмнэлгийн багаж хэрэгслүүд, бугуйн цаг, хөгжмийн зэмсэг гэх мэт), бүх төрлийн зэвсгийн үйлдвэрлэл, урлагийн бүтээлүүдийг оруулаагүй болно.

4. Дэлхийн банкны “Бизнес эрхлэхүй” тайлангийн экспортын бүрдүүлэлт хийх хугацаа

Дэлхийн Банкны 2018 оны "Бизнес эрхлэхүй" судалгааны тооцоогоор, Монгол Улс экспортын гаалийн бичиг баримтын бүрдүүлэлт хийх хугацаа нь 168 орчим цаг, хилийн бүрдүүлэлт хийх хугацаа нь 62 цаг гэж тодорхойлогдож, хил дамнасан худалдааны үзүүлэлтээр дэлхийд 110-т жагссан. Бүс нутгийн дундаж (68 цаг) болон өндөр орлоготой орнуудын дундажтай (2.4 цаг) харьцуулбал Монголын экспортын бүрдүүлэлт хийх хугацаа нь харьцангуй өндөр байна. Хилийн бүрдүүлэлт хийх хугацаа нь өндөр боловч, бүс нутгийн хэмжээнд харьцуулахуйц дундаж хэмжээнд багтаж байна (Хүснэгт 5-г харна уу). Үүнээс харвал, Монгол Экспорт хөтөлбөрт баримт бичигт бүрдүүлэлт хийх хугацааг хөтөлбөрийн үнэлгээний ахиц дэвшлийн хэмжүүр болгон ашиглахаар төлөвлөсөн нь тохиромжтой сонголт болохыг харуулж байна.

Хүснэгт 8. “Бизнес эрхлэхүй” тайлан 2018: Хил дамнасан худалдаа

Шалгуур үзүүлэлт	Монгол	Зүүн Ази, Номхон далайн	ЭЗХАХБ-ын өндөр орлоготой орнууд	Хамгийн сайн үзүүлэлтэй улс
Экспортын хугацаа: хилийн бүрдүүлэлт (цаг)	62	55.9	12.7	0 (17 улс)
Экспортын зардал: хилийн бүрдүүлэлт (Ам. доллар)	191	387.5	149.9	0 (19 улс)
Экспортын хугацаа: бичиг баримтын бүрдүүлэлт (цаг)	168	68.2	2.4	1.0 (25 улс)
Экспортын зардал: бичиг баримтын бүрдүүлэлт (Ам. доллар)	64	112.1	35.4	0 (19 улс)
Импортын хугацаа: хилийн бүрдүүлэлт (цаг)	48	70.5	8.7	0 (21 улс)
Импортын зардал: хилийн бүрдүүлэлт (Ам. доллар)	210	431.0	111.6	0 (27 улс)
Импортын хугацаа: бичиг баримтын бүрдүүлэлт (цаг)	115	65.6	3.5	1.0 (30 улс)
Импортын зардал: бичиг баримтын бүрдүүлэлт (Ам. доллар)	83	111.4	25.6	0 (30 улс)

Эх сурвалж: Дэлхийн банкны “Бизнес эрхлэхүй” тайлан 2018

5. Дэлхийн банкны “Бизнес эрхлэхүй” тайлангийн экспортын бүрдүүлэлт хийх зардал

Монголын экспортлогчдоос (тарифыг хасаж тооцсоноор) төлөх шууд зардлыг Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудтай харьцуулахад харьцангуй бага боловч ЭЗХАХБ-ын өндөр орлоготой орнуудаас их байна. Засгийн газар экспортын шууд зардлыг бууруулахыг хичээх хэрэгтэй боловч зарцуулсан цаг хугацааг харвал бусад бүс нутгийнхаас илүү өндөр байна. Тиймээс бид энэ хэсэгт гол шалгуур үзүүлэлтээр экспортын гаалийн болон хилийн бүрдүүлэлт хийхэд зарцуулах цаг хугацааг ашиглах нь зохистой хэмээн санал болгож байна.

6. Худалдааны түнш орнуудтай тарифын болон тарифын бус хориг саадыг бууруулах хэлэлцээр байгуулах

Одоо байгаа нэг хөтөлбөр нь зөвхөн Япон улстай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн гэрээ хэлэлцээрийг харгалзан үзсэн байна. Гэвч эдгээр төрлийн бүрэн хэмжээний цогц гэрээнүүд нь урт хугацааны туршид хоёр талын ихээхэн хэмжээний хүчин чармайлт

хамтын ажиллагаагаа шаарддаг. Тиймээс эдгээр нь худалдааны саад бэрхшээлийг хөнгөвчлөхөд чиглэсэн ГХЯ-ны хэрэгжүүлэх арга хэмжээний оновчтой хэмжүүр биш юм. Бусад хоёр талын болон олон талт хэлэлцээр нь экспортыг дэмжихэд хувь нэмрээ оруулахыг үгүйсгэхгүй. Тиймээс бид эдийн засгийн дунд хугацааны хөтөлбөрүүд болон бусад доод түвшний үйл ажиллагаа, эдийн засгийн гэрээнүүдийг ашиглахыг зөвлөж байна. Эдгээр нь экспортыг дэмжих арга хэмжээний ахиц болон үр нөлөөг хэмжих илүү ач холбогдолтой үзүүлэлт хэмээн үзэж байна.

Дээр дурдагдсан асуудлуудыг доорх **Error! Reference source not found.**-р хүснэгтэд нэгтгэн харуулав.

Хүснэгт 9. Монгол Экспорт 2018 хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийн тухай санал

Шалгуур үзүүлэлт		Санал
1	Нийт экспортод ХАА-н гаралтай боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин	Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин
2	Экспортын сагс дахь уул уурхайн бус бүтээгдэхүүний тоо	Бүтээгдэхүүний 4 оронгийн нарийвчлалыг ашиглах (2 оронгийн нарийвчлал бус)
3	Хөнгөн, хүнс, хөдөө аж ахуйн салбарын экспортын орлого	Уул уурхайн бус салбарын экспортын орлого
4	Дэлхийн банкны “Бизнес эрхлэх нь” тайлангийн экспортын бүрдүүлэлт хийх хугацаа	Дараахаас нэг хувилбарыг сонгох: - Бүх 4 үзүүлэлтийг ашиглах - Экспортын бүрдүүлэлт хийх хугацаа, зардал - Экспортын болон хилийн бүрдүүлэлт хийх хугацаа
5	Дэлхийн банкны “Бизнес эрхлэх нь” тайлангийн экспортын бүрдүүлэлт хийх зардал	
6	Худалдааны түнш орнуудтай тарифын болон тарифын хориг саадыг бууруулах хэлэлцээр байгуулах	Зөвхөн чөлөөт худалдааны хэлэлцээр бус, (жишээ нь Япон улстай байгуулсан эдийн засгийн түншлэлийн гэрээ) худалдааны саад тотгорыг бууруулах бус нутгийн болон 2 талт санаачилгыг оруулах

6. НИЙТ ЭКСПОРТЫН ШИНЖИЛГЭЭ – ТАТАЛЦЛЫН ЗАГВАР

Таталцлын загвар нь эмпирик судалгаанд өргөнөөр ашиглагддаг, үр дүнтэй судалгааны арга хэрэгсэл юм. Тус загвар нь анх 1960-аад онд шинэ онолын үндэслэл бүхий эмпирик загварчлал хэлбэрээр үүссэн. 2000-аад оны эхээр загварыг хөгжүүлж, эдийн засгийн агуулгыг улам хүчирхэг болгосон. Тус загвар нь аливаа улсуудын хоорондох худалдааны гэрээ, валютын ханшийн хэлбэлзэл, мөнгөн тэмдэгтийн нэгдмэл байдал, "хилийн нөлөө" болон худалдааны бусад хүчин зүйлсийн нөлөөг үнэлэхэд өргөнөөр ашигладаг.

Үнэлгээний аргыг судалгааны зорилго, тоон өгөгдлийн дутагдалтай байдал болон бусад хүчин зүйлсээс хамааран өөр өөрөөр сонгож болдог. Энэхүү судалгаанд Андерсон ба Винкүүпийн онолын загвар дээр суурилсан дараах таталцлын тэгшитгэлийг ашигласан (Anderson & Wincoop, 2003):

$$\ln(non_m_exp_{jt}) = \beta_0 + \beta_1 \ln(Y_{jt}) + \beta_2 \ln d_j + \beta_3 pol_{jt} + \beta_4(border * RTA) + \beta_5 * year_t + \epsilon_j$$

Үүнд:

<i>non_m_exp_{jt}</i>	<i>Монголоос j-р улс руу гаргаж буй уул уурхайн бус экспорт, жилээр</i>
<i>β₀</i>	<i>Регрессийн тогтмол</i>
<i>Y_{jt}</i>	<i>Импортлогч улсын ДНБ</i>
<i>d_j</i>	<i>Монгол болон j-р улсын хоорондын зай, км/миль</i>
<i>pol_{jt}</i>	<i>Бодлогын дамми хувьсагч. Монголын Засгийн газар j-р улс руу гаргаж буй уул уурхайн бус экспортыг дэмжихэд чиглэсэн бодлого, төсөл хэрэгжүүлсэн бол 1 утга авна.</i>
<i>border_j * RTA_j</i>	<i>Харилцан үйлчлэлийн дамми хувьсагч. Монгол ба худалдааны түнш орнууд хиллэдэг бөгөөд нэг бүс нутгийн худалдааны хэлэлцээрт гишүүнчлэлтэй үед 1 утга авна.</i>
<i>border_j</i>	<i>Хилийн дамми хувьсагч. Монгол улс болон j-р улс хиллэдэг бол 1 утга авна.</i>
<i>RTA</i>	<i>Бүс нутгийн худалдааны хэлэлцээрийн дамми хувьсагч. Монгол улс болон манай улсаас импортлогч улс хоёулаа нэг бүс нутгийн худалдааны хэлэлцээрт гишүүнчлэлтэй үед 1 утга авна.</i>

year_*

Жилийн дамми хувьсагч. 2010-2016 оны буюу 7 жилийн дамми хувьсагчаас бүрдэх ба Монгол Улсын экспорт дахь дэлхийн нөлөөг илэрхийлнэ.

Судалгааны баг стандарт таталцлын загварт бодлогын хувьсагч, Монгол ба худалдааны түнш орнуудтай холбоотой цаг хугацаанд өөрчлөгддөг болон өөрчлөгддөггүй нөлөөг тусгах дамми хувьсагчдыг нэмсэн. Эдгээр хувьсагчийг нэмээгүй тохиолдолд үнэлгээ нийцтэй биш болно. Учир нь ажиглагдахгүй, худалдаанд нөлөө үзүүлэх хувьсагчдыг орхигдуулах нь үнэлгээг гажуудахад хүргэнэ.

Судалгааны баг хүлээгдэж буй үр дүнг дараах байдлаар тодорхойлж байна:

- Таталцлын онолын дагуу импортлогч улсын ДНБ нь Монголын экспорттой эерэг хамааралтай;
- Монгол Улс болон импортлогч улсын хоорондын зай экспорттой урвуу хамааралтай;
- Тухайн хоёр улс газар зүйн байршлаараа ойр байх тусам хилийн болон РТА хувьсагчуудаас бүрдэх харилцан үйлчлэлийн хувьсагч нь экспортын хэмжээг нэмэгдүүлэх хандлагатай байна;
- Бодлогын хувьсагч нь Монголын Засгийн газар экспортыг татвараас чөлөөлөх, бага хүүтэй арилжааны зээлээр дамжуулан экспортыг дэмжих зэрэг санхүүгийн дэмжлэг үзүүлсэн тохиолдолд 1 гэсэн утга авна. Судалгааны баг тус хувьсагч экспортод эерэг нөлөө үзүүлнэ гэж таамаглаж байна.

Үнэлгээний гол зорилго нь манай улстай худалдаа хийдэг 35 худалдааны түнш орнуудын 7 жилийн панел тоон өгөгдлийг⁷ ашиглан өнгөрсөн хугацаанд хийгдсэн Засгийн газрын уул уурхайн бус экспортыг дэмжих бодлогын үр нөлөөг үнэлэхэд оршино. Эхлээд судалгааны баг экспортын татварын хөнгөлөлт болон бага хүүтэй арилжааны зээлийг төлөөлөх хоёр дамми хувьсагчдыг үнэлгээнд оруулсан. Үнэлгээний үр дүнд экспортын татвараас чөлөөлөх бодлого нь уул уурхайн бус экспортод нөлөөгүй гэсэн бидний таамаглал батлагдсан тул загвараас татвараас чөлөөлөх бодлогын дамми хувьсагчийг хассан. Үнэлгээний үр дүнг дараах зурагт харуулж байна.

⁷ Панел тоон мэдээллийг үнэлэхэд тогтмол болон санамсаргүй нөлөөний регрессийг ашигладаг. Зохистой аргыг тодорхойлохын тулд Хауссманы шалгуурыг ашигласан. Тестийн үр дүнг Хавсралт 6-д харуулсан.

Зураг 16. Үнэлгээний үр дүн

```

Random-effects GLS regression              Number of obs      =       244
Group variable: imp_id                     Number of groups   =        40

R-sq:                                     Obs per group:
    within = 0.0884                        min =              1
    between = 0.4817                       avg =             6.1
    overall = 0.4068                       max =             7

corr(u_i, X) = 0 (assumed)                Wald chi2(10)      =       52.81
                                           Prob > chi2        =       0.0000

```

ln_exp	Coef.	Std. Err.	z	P> z	[95% Conf. Interval]	
inter_1	4.235099	1.903769	2.22	0.026	.5037795	7.966419
ln_dist	-1.372313	.8284837	-1.66	0.098	-2.996111	.2514853
ln_impGDP	.9310976	.3108724	3.00	0.003	.321799	1.540396
policy_1	.9013183	.2595478	3.47	0.001	.392614	1.410023
year						
2011	-.6728396	.3270699	-2.06	0.040	-1.313885	-.0317944
2012	-.7003513	.3461169	-2.02	0.043	-1.378728	-.0219746
2013	-.2298161	.3410615	-0.67	0.500	-.8982845	.4386522
2014	-.0885684	.3406565	-0.26	0.795	-.7562428	.579106
2015	-.3239908	.3409698	-0.95	0.342	-.9922793	.3442978
2016	.1434296	.3000306	0.48	0.633	-.4446196	.7314788
_cons	7.788046	7.46036	1.04	0.297	-6.833991	22.41008
sigma_u	1.9726904					
sigma_e	1.1505643					
rho	.74617054	(fraction of variance due to u_i)				

Эх сурвалж: судлаачдын тооцоолол

Уул уурхайн бус экспортод нөлөөлж буй гол хүчин зүйлсийг дараах байдлаар эрэмбэлэн тайлбарлаж болно:

- Хэрвээ худалдааны түнш орон Монгол Улстай хиллэдэг бөгөөд нэг бүс нутгийн худалдааны хэлэлцээрт гишүүнчлэлтэй бол тухайн улс руу хийж буй экспорт 4.2 хувиар өсөх бөгөөд энэ нь бусад хүчин зүйлстэй харьцуулахад хамгийн өндөр нөлөөтэй хүчин зүйл байна. Үүнийг Монгол Улс хөрш зэргэлдээ орнууд болох БНХАУ, ОХУ-руу голчлон экспортолдог бөгөөд газарзүйн хувьд далайд гарцгүй байдалтай холбон тайлбарлаж болно.
- Монгол Улс болон худалдааны түнш орнуудын хоорондох зай 1 хувиар өсөхөд экспорт 1.4 хувиар буурна.
- Импортлогч улсын ДНБ 1 хувиар нэмэгдвэл Монгол Улсаас тухайн улс руу хийх экспортын хэмжээ 0.93 хувиар өсөх буюу эдгээр хувьсагчдын хоорондоо эерэг хамааралтай байна. Энэ үр дүн нь Таталцлын онолтой нийцтэй байна.
- Монгол Улсын Засгийн газар салбаруудад бага хүүтэй арилжааны зээл олгох байдлаар санхүүгийн дэмжлэг үзүүлбэл экспорт 0.9 хувиар өснө. Гэхдээ энэ бол

дамми хувьсагч дээр суурилсан ерөнхийлсөн үнэлгээ юм. Үнэлгээг цаашид улам сайжруулахын тулд бодит арилжааны зээлийн тоон өгөгдлийг ашиглавал илүү бодит үр дүн гарна.

Дээр дурдсан хүчин зүйлсээс гадна, Монгол Улсын экспортод жилийн дамми хувьсагчаар илэрхийлсэн гадаад хүчин зүйлс нөлөөлсөн. Үнэлгээний дараа судалгааны баг эдгээр хугацааны хувьсагчид үнэхээр уул уурхайн бус экспортод нөлөөлж буй эсэхийг хугацааны-санамсаргүй ашиглан шалгасан.

Зураг 17. Хугацааны-санамсаргүй нөлөөний шалгуур

```
. testparm i.year  
  
 ( 1)  2011.year = 0  
 ( 2)  2012.year = 0  
 ( 3)  2013.year = 0  
 ( 4)  2014.year = 0  
 ( 5)  2015.year = 0  
 ( 6)  2016.year = 0  
  
      chi2( 6) =    13.55  
      Prob > chi2 =    0.0352
```

Эх үүсвэр: судлаачдын тооцоолол

Зурагт харуулснаар бүх жилийн хувьсагчдын өмнөх коэффициентууд 0-тэй тэнцүү гэсэн тэг таамаглалыг үгүйсгэж байна. Тиймээс цаг хугацааны-санамсаргүй нөлөөгөөр үнэлэх нь энэ тохиолдолд зохистой байна. 2010 он буюу суурь онтой харьцуулахад дэлхийн эдийн засгийн манай улсын уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортод үзүүлэх нөлөө сөрөг байна. Энэхүү үр дүн нь 2010 он буюу суурь онд Монголын уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүн олон улсын зах зээлд илүү өрсөлдөх чадвартай байсныг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, манай экспортын бүтэц 2010 оноос хойш төрөлжөөгүй гэсэн үг юм. Дээр дурдсанчлан, Монгол улсын хувьд экспортолж буй ялгаварлалтай бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь өчүүхэн бага байна. Энэ нь Монгол Улсын экспортод дэлхийн зах зээлийн хүчин зүйлс сөрөг нөлөөтэйг тайлбарлах гол хүчин зүйл байж болох юм.

7. СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН, БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

Монгол Улс бол гадаад худалдаанаас ихээхэн хамааралтай жижиг нээлттэй эдийн засаг юм. Монгол Улсын экспортын салбар төрөлжөөгүй. Экспортын гол бүтээгдэхүүн гэвэл алт, зэс, нүүрс бөгөөд цөөн тооны уул уурхайн бус бүтээгдэхүүнийг экспортолж байна. Уул уурхайн салбараас хэт хамааралтай байдал нь дотоодын эдийн засгийг дэлхийн үнийн хэлбэлзэлд хэт өртөмтгий болгодог. Бараг бүх уул уурхайн экспорт БНХАУ-руу

чиглэдэг нь энэ хамаарлыг улам гүнзгийрүүлж байна. Хэдийгээр сүүлийн жилүүдэд БНХАУ-ын эдийн засаг тогтвортой байсан ч БНХАУ-ын бодлогын өөрчлөлтөөс үүдэн ирэх жилүүдэд металл болон нүүрсний өндөр эрэлт ихээхэн буурах хандлага ажиглагдаж байна. Мөн түүнчлэн, голлох экспортын бүтээгдэхүүн зөвхөн нэг зах зээлээс хамааралтай байх нь аль ч улс орны хувьд санаа зовоосон асуудлын нэг юм.

Манай улсын нийт экспортын орлогын 15 хүрэхгүй хувийг уул уурхайн бус экспорт бүрдүүлдэг бөгөөд энэ хувь хэмжээ нь 2000 оноос хойш тасралтгүй буурчээ. Ноос, ноолуур, нэхмэлийн бүтээгдэхүүн, арьс шир, арьс ширэн бүтээгдэхүүн, үндсэн металл, мах болон бусад малын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүн, ургамлын гаралтай бүтээгдэхүүн зэрэг цөөн хэдэн төрлийн бүтээгдэхүүн уул уурхайн бус экспортын орлогын 90 гаруй хувийг бүрлүүлдэг. Эдгээр цөөн тооны бүтээгдэхүүнээс зөвхөн хоёр бүтээгдэхүүн (ноос, ноолуур, нэхмэл бүтээгдэхүүн болон арьс шир, арьс ширэн бүтээгдэхүүн) харьцангуй давуу талтай байсан. Сүүлийн хоёр жилд уул уурхайн экспортын орлого огцом өссөнөөс шалтгаалан арьс ширний бүтээгдэхүүн харьцангуй давуу талаа алдаж, байдал улам муудсаар байгаа. Ялгаварлалтай бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь маш бага бөгөөд сүүлийн жилүүдэд хамгийн ихдээ 10 хувьд хүрсэн. Уул уурхайн бус экспортын худалдан авагч орнуудын тоо хумигдаж байна. Тухайлбал, БНХАУ-д экспортолж буй уул уурхайн бус бүтээгдэхүүний орлого нийт уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортын орлогод эзлэх хувь 2010 оноос хойш 16.8 хувиар өсөж, 2016 он гэхэд 72 хувьд хүрсэн. Мөн ОХУ болон Европын холбооны улсуудын эзлэх хувь пропорционалиар буурчээ.

Экспортын төрөлжилтгүй байдал болон уул уурхайн бус бүтээгдэхүүний салбарын нийт экспортод эзлэх хувийн жин буурч байгаатай холбоотойгоор засгийн газар тус нөхцөл байдалд анхаарлаа ихээр хандуулж байна. 2007-2021 онд хэрэгжүүлж байгаа Үндэсний хөгжлийн цогц бодлого зэрэг бодлогын баримт бичгүүдэд экспортын баримжаатай өсөлтийг Засгийн газрын тэргүүлэх чиглэл болгон зарласан. Энэхүү санаачилгыг Экспортыг дэмжих хөтөлбөр-2013, Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөр-2016, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2016-2020 зэрэг баримт бичгүүдэд мөн тусгажээ. Одоогийн Засгийн газар өмнөх хөтөлбөрийн шинэчилсэн хувилбар болох Монгол Экспорт Хөтөлбөр-2018-ийг боловсруулахаар төлөвлөн хэлэлцэж байна. Засгийн газар илүү эрчимтэй, илүү экспортод төвлөрсөн экспортыг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх хэрэгцээ байгааг олж харсан нь илэрхий харагдаж байна.

Засгийн газраас экспортыг дэмжих чиглэлээр нэлээд хүчин чармайлтыг гаргаж байгаа ч хэрэгжилт өнөөг хүртэл зогсонги байдалтай байна. Судалгааны баг экспортыг дэмжих "төвлөрлийг сааруулах төрийн загвар"-ын дагуу экспортын салбар дахь олон төрлийн тоглогчдын өнөөгийн институтийн бүтцийг тодорхойлсон. Сүүлийн арав гаруй жилийн хугацаанд гадаад худалдааг хариуцах гол чиг үүрэг нь нэг яамнаас нөгөөд шилжсээр ирсэн. Үүний зэрэгцээ Засгийн газрын агентлагууд, Хөгжлийн банк, ЖДҮ-ийг

хөгжүүлэх сан болон Дэлхийн Банк, бусад хоёр талт байгууллагууд зэрэг олон улсын байгууллагаас хөнгөлөлттэй зээл, олон янзын сургалтын хөтөлбөрүүд гэх мэт экспортыг дэмжих ажлууд хийгдсээр байна. Эдгээр үйл ажиллагааг өргөн хүрээний зохицуулалт, зохион байгуулалттайгаар хийж ирсэн. Экспортыг дэмжих байгууллагууд цөөхөн бөгөөд нягт холбоогүй ажилладаг тул тэдгээрийн үйл ажиллагаа нь өрсөлдөөнгүй өөр хоорондоо уялдаагүй байдаг.

Засгийн газрын гол хийж байгаа ажлууд нь ихэвчлэн хөнгөлөлттэй зээл, НӨАТ-ын хөнгөлөлт, үндэсний экспортлогчдод түүхий эд нийлүүлдэг малчдад татаас өгөх зэрэг санхүүгийн хэрэгслүүдэд чиглэж байна. Төсөв, бондын эх үүсвэрийн нэлээд хэсгийг ноос, ноолуур, нэхмэл болон арьс шир, арьс ширэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэхэд зориулдаг. Энэ хоёр салбарын харьцангуй давуу тал болон экспортын орлого зэрэг үзүүлэлтүүд сайн байгааг бид ажигласан. Гэсэн хэдий ч, төсвийн арга хэмжээнүүд экспортыг огцом өсгөхүйц нөлөөтэй байж чадахгүй байна гэж бид үзэж байна. Үүний зэрэгцээ үйлчилгээг сайжруулах зэрэг санхүүгийн бус хэрэгслийг ашиглах Засгийн газрын оролдлого хязгаарлагдмал байна. Дэлхийн Банкнаас эрхлэн гаргадаг “Бизнес эрхлэхүй” судалгааны хил дамнасан худалдааны шалгуур үзүүлэлтээр Монгол Улс 119 орноос 110-р байранд эрэмбэлэгдсэн. Ялангуяа, бичиг баримт бүрдүүлэх болон хил нэвтрэн өнгөрөхөд зарцуулдаг цаг хугацаа бүс нутгийн бусад орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байдаг. Тухайлбал, хэдэн жилийн өмнө эхэлсэн “Нэг цонх”-ны санаачилга одоо хүртэл хэрэгжилтийн явцдаа байсаар байна. Яармаг худалдаа, үзэсгэлэн, даатгал, гэрчилгээ, гарал үүсэл, сургалт, мэдээллийн семинар гэх мэт экспортлогчдод зориулсан бусад үйлчилгээнүүдийг ТББ-ууд (Худалдаа, аж үйлдвэрийн танхим), олон улсын агентлагууд тун цөөн зохион байгуулдаг.

Төрийн болон төрийн бус үйлчилгээг сайжруулах нь бүх экспортлогчид болон ирээдүйд бүтээгдэхүүнээ экспортлох боломжтой үйлдвэрлэгчдэд илүү ач холбогдолтой гэж үзэж байна. Эдгээр арга хэмжээ нь татварын хөнгөлөлт болон хөнгөлөлттэй зээлтэй харьцуулахад их хэмжээний санхүүгийн эх үүсвэр шаарддаггүй, улс төрийн нөлөөнд автдаггүй бөгөөд ялгаварлалтай бүтээгдэхүүний экспортод тулгардаг гол бэрхшээл болох мэдээллийн тэгш бус байдлын асуудлыг шийдвэрлэхэд илүү үр дүнтэй юм. Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй Монгол экспорт 2018 хөтөлбөр нь бодлогын арга хэрэгсэл, үйл ажиллагааны хувьд илүү өргөн хүрээтэй юм. Тухайлбал, тус хөтөлбөр нь санхүүгийн бус бодлогын хэрэгслүүдэд ихээхэн чиглэсэн байна.

Судалгааны баг 2010-2016 оныг хамарсан 35 худалдааны гол түнш улсуудын худалдаа, эдийн засаг, бодлогын хэрэгжилт зэрэг олон төрлийн тоон мэдээллийг ашиглан Таталцлын загварыг үнэлсэн. Үнэлгээний үр дүнд нэг бүс нутгийн худалдааны хэлэлцээрт гишүүнчлэлтэй бөгөөд газарзүйн хувьд хиллэдэг байх нь экспорттой эерэг хамааралтай (бусад хувьсагчаас илүү үр дүнтэй) байна. Хоёр орны хоорондын зай болон экспорт сөрөг хамааралтай. Импортлогч улсын ДНБ нь экспорттой эерэг хамааралтай

байна. Судалгааны баг Засгийн газраас олгосон хөнгөлөлттэй зээлийг бодлогын хувьсагч болгон ашигласан. Харамсалтай нь бид нийт олгосон зээлийн хэмжээний талаар баттай тоон мэдээлэл олж чадаагүй тул үүнийг дамми хувьсагчаар төлөөлүүлэн үнэлсэн. Энэ үнэлгээний үр дүнд бид хөнгөлөлттэй зээл нь экспорттой эерэг хамааралтай ба статистикийн хувьд ач холбогдолтой болохыг тогтоолоо.

Судалгааны багаас судалгааны үр дүнд үндэслэн дараах зөвлөмжүүдийг хүргүүлж байна:

- Энэхүү судалгаа үндэсний гадаад худалдаа, экспортын нягт уялдуулсан бодлого ач холбогдолтой болохыг харуулж байна. Тиймээс, Гадаад харилцааны яам (буюу гадаад худалдаа хариуцсан төрийн агентлаг) гадаад худалдааны бодлого боловсруулж, хяналт тавин ажиллах хэрэгтэй. Энэхүү чиг үүрэг нь Монгол экспорт хөтөлбөрт тусгагдсан бөгөөд даруй хэрэгжүүлэх шаардлагатай.
- Гадаад худалдааны чиг үүргийг нэг нэгжээс нөгөөд шилжүүлдэг байдал нь бодлогын нэгдмэл бус, тасалдалтай байдлыг үүсгэж байна. Цаашилбал, энэ нь мэргэжилтнүүд болон хүний нөөцийг алдахад хүргэж байна. Иймээс нэг нэгжийн хүрээнд экспортыг дэмжих нэгдмэл бодлогын хэрэгжилт, хяналтын чиг үүргийг тогтворжуулах шаардлагатай.
- Үндэсний нэгдмэл бодлого боловсруулж, амжилттай хэрэгжүүлэхэд зөвхөн бодлого боловсруулагчид төдийгүй олон талуудын оролцоог шаарддаг. Хорин жилийн өмнө (1998 он) Үндэсний экспортын зөвлөл экспортын бодлогыг хянах санаачилга гаргасан боловч хэдхэн жилийн дараа хэрэгжиж эхлэхээс өмнө цуцлагдсан. Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бодлогод хууль тогтоогчид, төрийн агентлагууд болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа шаардлагатай байдаг тул бүх талуудыг оролцуулсан зохион байгуулалтын нэгж (жишээ нь, зөвлөл) байгуулах нь зүйтэй юм.
- Гадаад харилцааны яам экспортыг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрөл бүрийн байгууллагуудын дунд удирдах чиг үүргийг үргэлжлүүлэн хүлээнээр өнөөгийн төвлөрсөн бус төрийн загвар хэвээр үлдэж магадгүй. Удирдах зөвлөл (ба / эсвэл ГХЯ) нь байгууллагууд болон санаачилгуудын бодлогын зохицуулагчийн үүргийг гүйцэтгэх хэрэгтэй. Гол төлөв төвлөрсөн бус агентууд өөрсдийн үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжтой байдаг тул зарим (хязгаарлагдмал) төвлөрсөн бодлогууд үр ашигтай байж болох юм. Бусад орны туршлагаас харахад хэт төвлөрөл нь хүнд суртал, хариу үйлдэл үзүүлдэггүй хөшүүн системд хүргэж болзошгүй байхад хэтэрхий хуваагдмал байдал, бодлогын түрэмгий шинж чанар ч мөн хүсээд байх зүйл биш юм.
- Экспорт, худалдааг дэмжихэд санхүүгийн болон санхүүгийн бус бодлогын хэрэгслүүдийг хослуулан ашиглах зүйтэй. Санхүүгийн хөшүүрэг зарим тохиолдолд үр ашигтай байдалд сөрөг нөлөө үзүүлдэг бөгөөд хямд зээлийн эх үүсвэр болон төсвийн орлогыг бууруулдаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Төсвийн орлого буурах нь төсвийн ихээхэн дарамттай байгаа өнөөгийн нөхцөлд онцгой хүндрэл учруулна.

Тиймээс хөнгөлөлттэй зээлийг олгож, татаас, татварын хөнгөлөлт үзүүлэхдээ эдгээр боломжийг ашиглах боломжтой хүмүүст зохих ёсоор хяналт шалгалт хийж үзэх хэрэгтэй. Хяналт шалгалт хийсний дараа эдгээр бодлогын "ялагчид"-ыг тодорхойлох ба бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд "зөв ялагч"-ийг тодруулах шаардлагатай. Засгийн газрын хүчин чармайлт болон эдгээр бодлогод энэ төрлийн хяналт шалгалт дутагдалтай байдаг нь бодлогын арга хэрэгслүүдийг үр нөлөөгүй болгодог.

- Судалгааны баг санхүүгийн бус бодлогын арга хэрэгслүүдийн ач холбогдлыг онцолж байна. Ийм төрлийн арга хэрэгслүүд зөвхөн одоогийн экспортлогчдод төдийгүй ирээдүйд бүтээгдэхүүнээ экспортлох боломжтой үйлдвэрлэгчдэд болон эдийн засгийн ерөнхий орчинд эерэг нөлөөтэй. Эрх зүйн орчныг сайжруулах нь экспортыг нэмэгдүүлэх түлхэц болно.
- Төрийн үйлчилгээг сайжруулах нь мэдээж тодорхой ач холбогдолтой. Мэдээж энэ нь зөвхөн экспортлогчдод бус бизнес эрхлэгчдэд ч үр ашигтай байна. Төрийн зарим үйлчилгээг товч дурдвал:
 - Гаалийн газар (бичиг баримт болон хилийн хяналт) – Нэг цонхны үйлчилгээ болон онлайн баримтжуулалт
 - Мэргэжлийн хяналт
 - Стандартчилал ба чанарын хяналт
 - Мэдээлэл болон тоон өгөгдлийн сан, судалгаа
- Төрийн бус байгууллага болон хувийн хэвшлийн үзүүлж болох бусад төрлийн үйлчилгээнүүд мөн байдаг. Бусад олон улсын жишгээр Засгийн газар хөтөлбөрийн эхний үе шат эхлэх үед төрийн санхүүгээр хангах үүрэг гүйцэтгэж болно. Эдгээр үйлчилгээг санхүүжүүлэх өөр нэгэн арга хэрэгсэл бол үйлчилгээний төлбөр юм. Эдгээр үйлчилгээгээр хангах болон дэмжихэд өндөр түвшний хамтын ажиллагаа болон зохицуулалт шаардлагатай:
 - Зах зээлийн мэдээлэл
 - Зар сурталчилгаа болон маркетинг
 - Даатгал
 - Сургалт, семинар
 - Экспортод хамааралтай судалгаа
 - Яармаг худалдаа болон үзэсгэлэн худалдаа
 - Нийлүүлэлтийн сүлжээний санаачилгууд
 - Судалгаа болон мэдээлэл
- “Монгол Экспорт Хөтөлбөр 2018”-ын зорилго, зорилтуудын талаар бид дээр товч дурдсан. Судалгааны баг экспортыг дэмжих бодлогын үр нөлөөг үнэлэхдээ нийт экспортод болон уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүний орлогод эзлэх аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хувь зэрэг тодорхой шалгууруудыг ашиглахыг зорьсон. Бид мөн хил давуулан худалдах явцыг хялбарчлахад гарах ахиц дэвшлийн хэмжүүр

болгон экспорт хийхэд шаардагдаж буй хугацаа (бичиг баримт бүрдүүлэлт, хилийн бүрдүүлэлт хоёрын аль алиныг)-г цаашдын үнэлгээнд ашиглахыг зөвлөж байна.

- Судалгааны багийн хөгжүүлсэн таталцлын загварын үр дүн нь хүлээгдэж буй үр дүнтэй нийцтэй байсан. Энд бодлогын дэмжлэг (хөнгөлөлттэй зээл) нь экспортод эерэг нөлөөтэй ба статистик ач холбогдолтой байсныг тэмдэглэх нь зүйтэй. Хэдий тийм ч энэхүү үнэлгээ нь бодлогын үр нөлөөг дамми хувьсагч ашиглан үнэлсэн бүдүүвчилсэн тооцоо гэдгийг онцлох хэрэгтэй. Цаашид үр дүнг илүү нарийвчилж, сайжруулахын тулд бодитоор олгосон зээлийн хэмжээний илүү дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай. Энэ төрлийн тоон өгөгдлийг цуглуулж, цаашид судалгаанд ашиглах боломжтой юм.
- Манай улсын экспортод дэлхийн зах зээл дэх өөрчлөлт сөрөг нөлөөтэйг бид ажигласан. Жилийн дамми хувьсагч сөрөг коэффициенттэй ба статистикийн хувьд ач холбогдолтой байгаа нь дэлхийн худалдааны чиг хандлага манай улсад сөрөг нөлөөтэй байгааг харуулж байна. Энэ нь манай улсын экспортын дийлэнх хэсгийг ялгаварлалгүй, нэмэгдэл өртөг шингээгүй бүтээгдэхүүн бүрдүүлдэгтэй холбоотой байна. Монгол Улсын уул уурхайн бус бүтээгдэхүүн харьцангуй давуу талаа алдаж буй нь үүнийг мөн баталж байна. Тиймээс бид гадаад худалдаанаас илүү үр өгөөж хүртэхийн тулд экспортын бүрэлдэхүүнийг төрөлжүүлж, сайжруулах шаардлагатай.
- Энэхүү судалгааг гүйцэтгэх болон олон төрлийн хөтөлбөрүүдийг үнэлэх явцад бид тоон мэдээллийн хязгаарлагдмал байдалтай тулгарсан. Засгийн газрын татаас болон хөнгөлөлттэй зээлийн бодит хэмжээний мэдээллийг олоход маш хүндрэлтэй байсан. ГХЯ экспортыг дэмжих хөтөлбөрүүдийн мэдээлэл болон экспортын салбарын тоон мэдээллийг нэг дор цуглуулж, бэлтгэх нь цаашид өндөр ач холбогдолтойг судалгааны багаас зөвлөж байна. Мөн экспортлогчдод зориулсан пүүсийн түвшний найдвартай мэдээллийг асуулгын судалгаагаар цуглуулан бэлтгэх нь чухал юм. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх нь экспортыг дэмжих бодлогын үр нөлөөг зөв үнэлэх, илүү нарийвчилсан судалгаа хийх боломж олгох төдийгүй бодлого боловсруулахад ихээхэн ач холбогдолтой.

HOM 3YЙ

- ADB. (2009). *Mongolia Country Progress Report on Implementation of Action Plan for Transport and Trade Facilitation Strategy*. Manila: ADB.
- ADB. (2016). *Trade and Industry Sector Assessment*. Manila: ADB.
- Ahmed, Z. M. (2002). Export promotion programs of Malaysian firms: International marketing perspective. *Journal of Business Research*, 55(10):831-43.
- Alvarez, R. a. (2000). Exporter performance and promotion instruments: Chilean empirical evidence. *Estudios de Economia*, 27(2): 225-41.
- Anderson, J. E., & Wincoop, E. v. (2003). Gravity with Gravitas: A Solution to the Border Puzzle. *American Economic Review*, Vol. 93, No. 1, 170-92.
- Balassa, B. (1965). Trade Liberalization and 'Revealed' Comparative Advantage. *The Manchester School* 33, 99-123.
- Balassa, B., & Noland, M. (1989). ``Revealed" Comparative Advantage in Japan and the United States . *Journal of International Economic Integration*, Vol. 4, No. 2, 8-22.
- Bowen, H. P. (1983). On the theoretical interpretation of indices of trade intensity and revealed comparative advantage. *Review of World Economics (Weltwirtschaftliches Archiv)*, vol.119, 464-72.
- Donges, j. B., & Riedel, J. (1977). The Expansion of Manufactured Exports in Developing Countries: An Empirical Assessment of Supply and Demand Issues. *Weltwirtschaftliches Archiv*, vol.113, 58-87.
- Economic Research Institute. (2014a). *Impact Assessment of Erdenes Tavan Tolgoi*. Ulaanbaatar: Economic Research Institute.
- Economic Research Institute. (2014b). *Impact Assessment of Iron Ore's sector*. Ulaanbaatar: Economic Research Institute.
- Economic Research Institute. (2016). *Impact Assessment of the Coal-To-Liquid project on the Mongolian Economy*. Ulaanbaatar: Economic Research Institute.
- Galindev, R. (2014). Impact of Fiscal Stability Law. *ERI Discussion Paper Series*, 1-33.
- Galindev, R., Baatarzorig, T., Bayarjargal, M.-I., Nyamdorj, N., Tur, T., & Batdelger, T. (2016). *A static CGE model of the Mongolian economy*. Partnership for Economic Policy.

- Gotz-Debnicka, E., & Baigalmaa. (2014). *Fact Finding Analysis on SMEs Export Promotion Policy, Instruments and Tools of Mongolia and Countries in Transition*. Ulaanbaatar: Report prepared for GTZ Export-oriented Industrial and Trade Policy Project, Project No. G/21/04.
- Heckman, J. a. (1985). Althervative methods for eveluating the the impact of interventions. *Journal of Econometrics*, 30(1): 239-67.
- Herzer, D. a.-L. (2006). What does export diversification do for growth? *Applied Economics*, 38(15): 1825-38.
- IMF. (2017). *IMF Country Report No. 17/140*. Washington D.C: IMF.
- Johansen, L. (1960). *A Multisectoral Study of Economic Growth*,. Amsterdam: North-Holland
- Jordana, J. M. (2010). *Export promotion organizations in Latin American and the Caribbean: An institutional portrait*. Washington,DC: IDB, Working Paper 198.
- Muendler, M.-A. (2007). *Balassa (1965) Comparative Advantage*. San Diego.
- Natural Resource Government Institute & Gerege Partners. (2017). *Fiscal Sustainability in Mongolia*. Ulaanbaatar: Natural Resource Government Institute.
- NSO. (2012). *Population projections 2010-2040*. Ulaanbaatar: NSO.
- Parliament of Mongolia. (2017). *The fiscal framework statements of 2019 and 2020*. Ulaanbaatar: Parliament of Mongolia.
- Raballand, G. (2003). Determinants of the Negative Impact of Being Landlocked on Trade: An Empirical Investigation Through the Central Asian Case. *Comparative Economic Studies*, vol. 45, 520-36.
- Vollrath, T. (1991). A theoretical evaluation of alternative trade intensity measures of revealed comparative advantage. *Review of World Economics (Weltwirtschaftliches Archiv)*, vol.127, 265-80.
- Volpe Martincus, C. a. (2012). Export promotion activities in developing countries: What kind of trade do they promote? *Journal of International Trade and Economic Development*, Vol.21(4):539-378.
- Vorshilov, E., & Ulzii-Ochir, N. (2016). Analyzing the Impacts of Mongolia's Trade Costs. *The Northeast Asian Economic Review*, Vol. 4, No. 2, 3-19.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Ялгаварлалтай бүтээгдэхүүний жишээ, сая ам. доллар

Ялгаварлалтай бүтээгдэхүүн нь бусад нийлүүлэгчдийн бүтээгдэхүүнтэй харьцуулбал өвөрмөц шинж чанартай байдаг. Тиймээс ялгаварлалтай бүтээгдэхүүнүүдийг бусад бүтээгдэхүүнээр амархан орлуулж болохгүй ба тухайн улс болон олон улсын зах зээлд урт хугацаанд өрсөлдөх чадвартай сайтай байх нь чухал ач холбогдолтой. Судалгааны баг бүтээгдэхүүнүүдийн шинж чанар дээр тулгуурлан ялгаварлалтай болон ялгаварлалгүй бүтээгдэхүүнүүдийг тодорхойлсон. Дараах хүснэгтэд ямар бүтээгдэхүүнийг ялгаварлалтай бүтээгдэхүүний бүлэгт бүлэглэснийг харуулав.

Хүснэгт А1. Ялгаварлалтай болон ялгаварлалгүй бүтээгдэхүүн (2 оронтой ангиллын дагуу)

Дугаар	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
61	20,835.6	25,177.3	22,905.5	22495.9	23,781	25,313.6	27,538.2	33047.0
05	10,998.0	13,810.5	11,952.5	12,995.7	9,150.6	12,412.6	10,224.2	12013.0
62	1,600.8	820.3	233.8	408.6	410.1	582.2	2,096.9	7105.0
57	2,182.7	2,985.2	3,159.9	1,021.8	2,268.9	2,018.5	1,964.5	1060.0
42	752.2	293.1	232.7	337.7	190.5	888.4	5,863.0	401.0
63	710.7	936.4	1,134.8	903.3	1,034.9	1,211.3	802.4	1922.0
43	27.9	25.0	36.2	5.8	31.6	134.9	191.0	345.0
56	21.9	12.4	20.8	34.3	63.1	72.8	25.0	16.0

Жич: 05 дугаартай бүтээгдэхүүн нь бусад газар заагдаагүй, мал амьтны гаралтай бүтээгдэхүүнээс бүрдэнэ. 42 дугаартай бүтээгдэхүүн нь боловсруулсан арьс ширэн эдлэл; суран эдлэл ба тоног хэрэгсэл; аяны хэрэгсэл; эмэгтэй хүний цүнх зэргээс бүрдэнэ. 43 дугаартай бүтээгдэхүүн нь үслэг арьс ба хиймэл үслэг арьс; тэдгээрээр хийсэн эдлэлээс бүрдэнэ. 56 дугаартай бүтээгдэхүүн нь Зулмал хөвөн, эсгий ба нэхээсгүй материал; өвөрмөц ээрмэл; олс, оосор, дээс, татлага ба тэдгээрээр хийсэн зүйлсээс бүрдэнэ. 57 дугаартай бүтээгдэхүүн нь Хивс болон нэхмэл дэвсгэрээс бүрдэнэ. 61 дугаартай бүтээгдэхүүн нь сүлжмэл хувцас ба хувцасны сүлжмэл тоног хэрэгсэлээс бүрдэнэ. 62 дугаартай бүтээгдэхүүн нь оёмол хувцас ба хувцасны оёмол тоног хэрэгсэлээс бүрдэнэ. 63 дугаартай бүтээгдэхүүн нь бусад нэхмэл бэлэн эдлэл; иж бүрдэл; хуучин хувцас ба хуучин нэхмэл эдлэл; хаягдал даавуунаас бүрдэнэ.

Уул уурхайн бус экспортод хамаарах бусад бүтээгдэхүүн нь ялгаварлалгүй бүтээгдэхүүн бөгөөд эдгээр бүтээгдэхүүнийг өрсөлдөгч нийлүүлэгчийн бусад бүтээгдэхүүнээр хялбархан орлуулах боломжтой. Монгол улсын хувьд энэ төрлийн бүтээгдэхүүний уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортод эзлэх хувь харьцангуй өндөр байдаг. Өөрөөр хэлбэл, Монгол улс экспортын бүтээгдэхүүний төрлийг олшруулах, ялгаварлалтай бүтээгдэхүүний экспортод эзлэх хувийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Судалгааны баг нь уул уурхай, хөдөө аж ахуйн салбарыг бүтээгдэхүүнийг ялгаварлалгүй гэж ангилсан бөгөөд эдгээр бүтээгдэхүүнийг өрсөлдөгч нийлүүлэгчийн бусад бүтээгдэхүүнээр амархан орлуулах боломжтой гэж үзлээ.

Хавсралт 2. Аргазүйн дэлгэрэнгүй техникийн мэдээлэл

Илэрсэн харьцангуй давуу тал (ИХДТ):

Бид тайлангийн судлагдсан байдал хэсэгт ИХДТ⁸-ын гол индексүүдийг танилцуулсан. ИХДТ-ын анхны томъёог 1965 онд Баласса тодорхойлж түүнийг "Стандарт Балассагийн ИХДТ индекс" хэмээн нэрлэх болсон.

$$\text{ИХДТ}_{ij}^1 = \frac{X_{ij}}{\sum_i X_{ij}} \div \frac{\sum_j X_{ij}}{\sum_i \sum_j X_{ij}}$$

Үүнд X_{ij} нь i улсын j бүтээгдэхүүний экспортыг илэрхийлдэг. Хэрэв $\text{ИХДТ}_{ij}^1 > 1$ байвал, i улс j бүтээгдэхүүн дээр харьцангуй давуу талтай гэж үзнэ. Харин $\text{ИХДТ}_{ij}^1 < 1$ байвал, i улс j бүтээгдэхүүн дээр харьцангуй давуу талгүй гэж үзнэ.

Мөн Донгэс болон Ридэл (1997) ИХДТ-ын өөр томъёог санал болгосон.

$$\text{ИХДТ}_{ij}^2 = \frac{X_{ij} - M_{ij}}{\sum_i (X_{ij} + M_{ij})} \div \frac{\sum_j X_{ij} - \sum_j M_{ij}}{\sum_i X_{ij} + \sum_j M_{ij}}$$

Үүнд X_{ij} болон M_{ij} нь i улсын j бүтээгдэхүүний экспорт болон импортыг илэрхийлдэг. Стандарт Балассагийн ИХДТ индекстэй харьцуулбал, ИХДТ_{ij}^2 нь зөвхөн экспортын бус харин улсын цэвэр экспортыг авч үздэг ба энэ нь 1-ээс илүү утгатай байвал тухайн улс нь j бүтээгдэхүүний хувьд харьцангуй давуу талтай гэж үзэж болно.

1983 онд Бовэн ИХДТ индексийг тооцоолох шинэ томъёог санал болгосон.

$$\text{ИХДТ}_{ij}^3 = \frac{T_{ij}}{Y_i} \div \frac{\sum_i Q_{ij}}{Y_w}$$

Үүнд Q_{ij} , T_{ij} нь i улсын j бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон цэвэр худалдааг (үйлдвэрлэл - хэрэглээ) илэрхийлдэг бол Y_i , Y_w нь i улсын ҮНБ, мөн дэлхийн ҮНБ-г илэрхийлдэг байна. Хэрэв $\text{ИХДТ}_{ij}^3 > 0$ байвал, i улс j бүтээгдэхүүн дээр харьцангуй давуу талтай гэж үзнэ.

Мөн 1991 онд, Волрат дараах ИХДТ-ын томъёонуудыг санал болгосон.

$$\text{ИХДТ}_{ij}^4 = \frac{X_{ij}/X_{ik}}{X_{nj}/X_{nk}} - \frac{M_{ij}/M_{ik}}{M_{nj}/M_{nk}}$$

⁸ "Илэрсэн" гэдэг үг нь тухайн улсын экспортын бүтцээс харьцангуй давуу талыг тооцдогтой холбоотой юм. Өөрөөр хэлбэл, тухайн улс j бүтээгдэхүүнийг голчлон экспортолдог нь тухайн улсын харьцангуй давуу талаас үүдэлтэй юм.

$$\text{ИХДТ}_{ij}^5 = \ln \left(\frac{X_{ij}/X_{ik}}{X_{nj}/X_{nk}} \right)$$

$$\text{ИХДТ}_{ij}^6 = \ln \left(\frac{M_{ij}/M_{ik}}{M_{nj}/M_{nk}} \right)$$

Үүнд X_{ij}, X_{ik} нь i улсын j бүтээгдэхүүний нийт экспорт болон j -ээс бусад бүтээгдэхүүний нийт экспортыг илэрхийлдэг. Харин M_{ij} болон M нь i улсын j бүтээгдэхүүний нийт импорт болон j -ээс бусад бүтээгдэхүүний нийт импортыг илэрхийлдэг. Индекс нь эерэг утгатай байвал харьцангуй давуу талыг харуулдаг харин сөрөг утга байвал тухайн улс харьцангуй сул талтай гэж үзэж болно.

Бид ИХДТ-ын индексийг өөр өөр томъёогоор тооцоолж болох боловч эдгээр томъёонууд i улсын j бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн харьцангуй давуу талын хувьд ижил үр дүнд хүргэнэ.

ИХДТ-ын хувиралтыг хэрэглэх:

Балассагын стандарт ИХДТ индекс нь зөвхөн бүтээгдэхүүний нэг агшин дах харьцангуй давуу талыг харуулдаг сул талтай. Бүтээгдэхүүний харьцангуй давуу талын өөрчлөлтийг илүү сайн ойлгохын тулд бүтээгдэхүүн нь t - гэс $t+1$ цагийн хооронд тогтвортой харьцангуй давуу талтай байдаг бенчмарк ИХДТ индекс тооцоолох хэрэгтэй. Үүний дараа, бодит ИХДТ индексийг тооцоолж, бенчмарк индекстэй харьцуулснаар бүтээгдэхүүний харьцангуй давуу талын өөрчлөлтийг зөв тооцно.

Бенчмарк ИХДТ индекс тооцоолохдоо, тухайн улсын t - гэс $t+1$ цагийн хооронд 2 зах зээл дах эзлэх хувийн жингийн харьцаа нь тогтвортой байвал түүний харьцангуй давуу тал мөн тогтвортой байна. Үүнийг доорх томъёогоор илэрхийлж болно.

$$\frac{\tilde{s}_{ij,t+1}}{\tilde{s}_{ik,t+1}} = \frac{s_{ij,t}}{s_{ik,t}}$$

Үүнд $\tilde{s}_{ij,t+1}$ нь тогтвортой харьцангуй давуу талтай үеийн i улсын $t+1$ цагт j зах зээлд эзлэх хувийн жин бөгөөд $\tilde{s}_{ik,t+1}$ нь i улсын $t+1$ цагт k зах зээлд эзлэх хувийн жин болно.

Мөн, зах зээл бүрд эзлэх хувь нь ижил төвшнөөр өссөн тохиолдолд i улсын харьцангуй давуу тал нь тогтвортой байна. Тогтвортой харьцангуй давуу талтай үед i бүтээгдэхүүний нийт экспортын хувьд өмнөх тэгшитгэлийг задалбал, дараах тэгшитгэл үүснэ.

$$\tilde{E}_{ij,t+1} = \alpha s_{ij,t} E_{j,t+1}$$

Үүнд $\tilde{E}_{ij,t+1}$ нь тогтвортой харьцангуй давуу талтай үеийн i улсын $t+1$ цагийн j бүтээгдэхүүний нийт экспорт ба α нь эерэг утгатай тогтмол тогтмол байна.

Мөн, i улсын j бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийн төрөлжилтийг оруулбал, i улсын j бүтээгдэхүүний тогтвортой харьцангуй давуу талын бенчмаркыг тодорхойлсон доорх тэгшитгэл үүснэ.

$$\tilde{E}_{ij,t+1} = \tilde{c}_{ij,t} E_{j,t+1}$$

$$\tilde{c}_{ij,t} = \frac{s_{ij,t} E_{j,t+1}}{\sum_{jk} s_{ijk,t} E_{jk,t+1}} \text{ орлуулахад дараах тэгшитгэл үүснэ.}$$

$$\tilde{E}_{ij,t+1} = \frac{s_{ij,t} E_{j,t+1} E_{i,t+1}}{\sum_{jk} s_{ijk,t} E_{jk,t+1}}$$

$\tilde{E}_{ij,t+1}$ нь тогтвортой харьцангуй давуу талтай үеийг илэрхийлдэг учраас, тогтвортой харьцангуй давуу талын бенчмарк-аас ямар нэгэн хэлбэлзэл байвал, тухайн хэлбэлзэл нь цаг хугацааны хоорондын харьцангуй давуу талын өөрчлөлтийг илэрхийлдэг. ИХДТ-ын өөрчлөлтийг (ИХДТӨ) дараах томъёогоор тооцож болно.

$$\text{ИХДТӨ}_{ij} = \frac{E_{ij,t+1}/E_{i,t+1}}{E_{j,t+1}/E_{t+1}} - \frac{\tilde{E}_{ij,t+1}/E_{i,t+1}}{E_{j,t+1}/E_{t+1}} = \text{ИХДТ}_{ij,t+1} - \beta \text{ИХДТ}_{ij,t}$$

Үүнд $\beta = \frac{1+g}{1+\sum_j c_{ij,t} g_j}$, $g_j = (E_{j,t+1} - E_{i,t})/E_{j,t}$ нь j бүтээгдэхүүний t -гээс $t+1$ цагийн хооронд дэлхийн экспортын өсөлтийг илэрхийлдэг бол $g = (E_{t+1} - E_t)/E_t$ нь нийт бүтээгдэхүүний дэлхийн экспортын өсөлтийг илэрхийлдэг.

ИХДТ-ын индекс нь ИХДТӨ-гийн хувьд дараах байдлаар илэрхийлэгдэж болно.

$$\text{ИХДТӨ}_{ij} = \frac{S_{ij,t+1}}{S_{i,t+1}} - \frac{\tilde{S}_{ij,t+1}}{S_{i,t+1}} \text{ болон } \text{ИХДТ}_{ij} = \frac{C_{ij,t+1}}{C_{j,t+1}} - \frac{\tilde{C}_{ij,t+1}}{C_{j,t+1}}$$

Хэрэв ИХДТӨ_{ij} нь эерэг утгатай бол, i улсын j бүтээгдэхүүний харьцангуй давуу тал нь өссөн, харин ИХДТӨ_{ij} нь сөрөг утгатай байвал харьцангуй давуу тал нь буурсан гэж үзэж болно.

Хавсралт 3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2016-2020 дэх экспортыг дэмжих үйл ажиллагаа

ЗГҮАХ-г тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн н хэмжээ (сая төгрөг)	Хүрэх түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)								Хэрэгжүүлэх байгууллага		
						2017 он		2018 он		2019 он		2020 он		Үндсэн	Хамтрагч	Оролцогч
						Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв			
НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ОНЦГОЙ БОДЛОГО																
1.14. Үндэсний хөрөнгө оруулагчдыг бүхий л талаар дэмжиж, эхний хөрөнгө оруулалтаа нөхөх хүртэл орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	1	Импортын барааг орлох бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа үндэсний хөрөнгө оруулагчдыг эдийн засгийн салбарын ангилал /хүнсний үйлдвэрлэл, хувцас болон нэхмэлийн үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэл, газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл/-д үндэслэн дэмжих, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах	2017-2018	-	-	1-ээс доошгүй хуулийн төсөл боловсруулж батлуулах	-	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	-	СЯ	-	-
1.23. “Үндэсний үйлдвэрлэл” хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.	1	Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд "Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр", "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр" боловсруулж хэрэгжүүлэх	2017-2020		-	Хөтөлбөр батлагдаж, хэрэгжиж эхлэх	-	Хөтөлбөр хэрэгжих	-	Хөтөлбөр хэрэгжих	-	Хөтөлбөр хэрэгжих	-	ХХААХҮЯ	-	-
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО																
